

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-21</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>22 -66</i>
<hr/>	
<i>1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>23-32</i>
<i>2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>32-36</i>
<i>3. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий/</i>	<i>36-37</i>
<i>4. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>37-66</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 01-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Ч.Хүрэлбаатар;
Томилолттой: Ж.Батжаргал, С.Одонтуяа, Б.Чойжилсүрэн.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдаанд оролцов.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Раднаасэд нар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хэлэлцэх асуудлын дарааллын 5, 6 дугаарт байгаа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасахаар тогтов.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, С.Тэгшжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэх талаарх нийтийн өргөдлийн талаар, Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай болон тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 11 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Инновацын бодлогын газрын дарга Т.Золзаяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл нар байлцав.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж хариулж, тайлбар хийв.

Төслийн 3, 4, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адъяаа, П.Анужин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Н.Энхболд, Ж.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/59 дүгээр зүйлийн 59.3.5 дахь заалт:

“59.3.5.өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчилж, тус заалтын 59.8, 59.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.8.Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс энэ хуулийн 59.3.5-д заасан итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийг сумын орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилна.

59.9.Энэ хуулийн 59.7, 59.8-д заасны дагуу орлогын шилжүүлгийг тодорхойлсны дараа орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн үлдсэн хэсгийг энэ хуулийн 59.3.1, 59.3.2, 59.3.3-т заасан итгэлцүүрээр тодорхойлно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 3 дахь заалт болгон өөрчилж, тус зүйлийн 60.2.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“60.2.10.энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 1 дэх заалтын 59.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.2.2.энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилна:

59.2.2.1.хүн амын тоо;

59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.2.2.3.ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.”

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 7.9 дэх хэсгийн “төсвийн” гэснийг хасаж, “гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэснийг “эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “3.1.2, 4.1.3-4.1.10-т заасан нийтээр тэмдэглэх баярын болон” гэснийг “3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Тогтохсүрэн хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 23.9, 23.10 дахь хэсэг, Тайлбарыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 57.18 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5.4 дэх заалтын “тагнуул,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан, Төслийн гарчгийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “2025 онд 40, 2026 оноос 65” гэснийг “2025 оноос 65” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “дуудлага худалдааны” гэж” гэсний дараа “, 139 дүгээр зүйлийн 139.1.17 дахь заалтын “сонгон шалгаруулалтад” гэснийг “дуудлага худалдаанд” гэж” гэж, “зураасан” гэсний дараа “болон түүнтэй адилтгах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн хувь хүн” гэснийг “Хувь хүн” гэж, 15.7 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхтэй албан татвар” гэснийг “Энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх албан татвар” гэж,” 21 дүгээр зүйлийн 21.2.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “20.1-д” гэснийг “20.1, 20.4-т” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 21.2.5, 25.1.6 дахь заалт, 27.1 дэх хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.16 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 15.6, 15.7 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл, 1

дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.17 дахь хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл тус тус дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 20.4, 20.5 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалтын 23.17 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Долоо.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.15, 22.5.16 дахь заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.17 дахь заалтыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 18 дугаар зүйлийн 18.13, 18.14 дэх хэсэг, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 20.2.4 заалт, 24.5 дахь хэсгийн дугаарын өөрчлөлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, мөн зүйлийн 26.15 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 18.13, 18.14 дэх хэсэг, 3 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 22.5.15 дахь заалтын “цэс” гэснийг “цэсийн” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.15, 22.5.16, 22.5.17 дахь заалтуудын “тус тус хөнгөлнө.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Найм.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “татварын хуульд зааснаас бусад” гэснийг “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.8-д, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24.5-д зааснаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Ес.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.3.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд худалдах гэрээг байгуулахад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан гэрээг байгуулахдаа тухайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дундаж үнийг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.15.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул-олборлолтын ажлыг хамтад нь гүйцэтгэх этгээдтэй арав хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулахаар тендер зарлаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван нэг.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын

даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат нар хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийн 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5

Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.3 дахь хэсгийн “сумын газар зохион байгуулалтын” гэснийг “энэ хуулийн 25.1.4-т заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.2.4 дэх заалтын “эрхлэх,” гэсний дараа “тухайн жилд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.10 дахь заалтын “байгууллага, мэргэжлийн байгууллагад” гэснийг “байгууллагад мэргэжлийн байгууллагын” гэж өөрчлөн, “, дүгнэлт өгөх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.15 дахь заалтын “Засгийн газарт” гэснийг “холбогдох хуульд заасан эрх бүхий этгээдэд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 23.2.16 дахь заалт нэмэх:

“23.2.16.улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: 6.Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.23 дахь заалт нэмэх:

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга объектыг төрийн өмчид хураан авах ажлыг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд гаргасан саналаа тайларлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 7
Бүгд: 11
36.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван хоёр.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2.8, 10.2.9 дэх заалт нэмсүгэй:

“10.2.8.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;

10.2.9.газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дарааллыг тогтоох, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8 дахь заалтын дугаарыг “10.2.10” гэж өөрчилсүгэй.”

3 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийг хүчингүй болгосугай. ” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан 2 цаг 50 минут үргэлжилж, 13 цаг 22 минутаас 14 цаг 41 минутад түр завсарлав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Тэмүүлэн: Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг 4 дүгээр зүйл болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван гурав.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Найруулгын санал:

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэснийг “болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван дөрөв.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “бүхий QR код (лавлагаа авах холбоос)” гэснийг, тус зүйлийн “, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “энгийн” гэсний дараа “болон тусгай” гэж, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа” гэсний дараа “ажлын” гэж тус тус” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “бичиг” гэсний өмнө “олгоно.” гэсний өмнөх” гэж, мөн зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа 10 хоног” гэснийг “хугацаа ажлын 10 өдөр” гэж тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван тав.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “, ӨӨРЧЛӨЛТ” гэснийг болон 2 дугаар зүйлийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван зургаа.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийг “Тогтоолд нэмэлт оруулах тухай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26,” гэсний дараа “27,” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4

Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван долоо. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “төсвийн тухай хууль” гэснийг “төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван найм. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн тэмдэглэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газрын” гэсний өмнө “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арван ес. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, төвлөрлийг сааруулах зорилгоор 2024 оныг “Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих” жил болгон зарласугай.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчилж, тус заалтын 11 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11/ Газрын багц хуулийн төсөл, түүнд нийцүүлэн Ашигт малтмалын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулан 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 12 дахь дэд заалт нэмэх:

“12/төсвийн ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлж төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөр, арга хэмжээний үр дүн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж түүнтэй уялдсан төсвийн зардлыг тооцож боловсруулж байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын “нийтлэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын гаргасан, Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай:

1/орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нийслэл, орон нутагт үе шаттайгаар нэмэгдүүлэх;

2/ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө орон нутгийн иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах;

3/агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м2-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах.” гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг сунгах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/ -т даалгасугай.” гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

“5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт шинээр нэмэх:

3/Ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө, орон нутагт орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Д.Тогтохсүрэн үг хэлж, санал хураалт явуулахгүй байх горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хорь.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй нэгтгэж нэг төсөл болгон, төслийн 1 дэх заалтыг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтын 13 дахь дэд заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13/хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан болон тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, төмөр зам, нисэх буудал, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчлэх, боомтын хүчин чадлыг сайжруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц бий болгох болон төрийн үйлчилгээний салбарын төсөл хөтөлбөрийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 16 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 10 цаг 32 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн байна. Ирц одоогийн байдлаар 52,6 хувьтай байна. Та бүхэнд өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Ганибалын Амартүвшин, Цогт-Очирын Анандбазар гишүүн, Хавдисламын Баделхан гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Шадарбалын Раднаасэд гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн гэсэн нийт 10 гишүүн хүрэлцэн ирснээр өнөөдрийн буюу 2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаан нээснийг та бүхэндээ мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт. Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж 10 мянга гаруй иргэдээс ирүүлсэн “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэх” талаарх нийтийн өргөдлийг хэлэлцэх.

2-т Байнгын хорооны тогтоолын төсөл “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай”

3-д Байнгын хорооны тогтоолын төсөл “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай”

4 дүгээрт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд анхны хэлэлцүүлэг

5 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл мөн анхны хэлэлцүүлэг

6 дугаарт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 онд төсвийн тухай хуулийн төслүүд хоёр дахь хэлэлцүүлэг гэсэн ийм хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулж байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Тогтохсүрэн гишүүн байна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ өглөөний мэнд хүргэе. Өнөөдрийн хэлэлцэх асуудлын 5, 6 хоёрыг хойшлуулах санал гаргах гэж байгаа юм. 5 дугаар асуудал нь Төсвийн хүрээний мэдэгдэл, 6 дугаар асуудал нь Төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг. Яах вэ, ажлын хэсэг дээр ажиллаж байгаа. Гэхдээ цаг хугацаа их шахуу байгаа. 2 дугаар хэлэлцүүлэг маань өөрөө бүх хэлэлцүүлгийн хамгийн гол хэлэлцүүлэг байдаг. Их олон саналууд ирсэн. Тийм учраас бид нар бас олон удаа хуралдаад ч байсан гэсэн техник ажиллагаа бас маш их байна. Ийм учраас би ямар санал тавих гэж байна вэ гэхээр өнөөдрийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс Төсвийн хуулийн 2 дугаар хэлэлцүүлэг, Төсвийн хүрээний мэдэгдэл 2-ыг хойшлуулж хасаад, ирэх 1 дэх өдөр

юм уу, 2 дахь өдрийн аль нэгэнд хуралдаад, тэгээд ирэх 7 хоногтоо 2, 3 хоёрыг бараг зэрэг шахуу хийчих бололцоо гарах болов уу гэж бодож байна. Ингэхгүй л бол 2-ыг их нухацтай сайн үзэж судалж байж оруулахгүй бол болохгүй байгаад байгаа юм.

Харин дагасан хуулиуд нь бол түрүүлж явдаг учраас өнөөдөр бол явчих нь зөв байх гэж бодож байна. Тийм учраас 5, 6 дугаар асуудлыг хойшлуулах санал гаргаж байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүн 2 асуудлыг хасах санал гаргаж, хойшлуулах санал гаргаж байна. Раднаасэд гишүүний микрофон. Картаа дахиад уншуул гэж байх шиг байна. Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Тогтохсүрэн гишүүний гаргасан саналтай холбогдуулж хэлэх зүйл байна. Одоо энэ 2, 3 хоёр чинь цуг явахаар 2 дээр чинь хамтдаа ер нь хугацааны хувьд ойрхон явах юм байна. Зарчмын зөрүүтэй маш олон санал гарна. Тэр дотор хөдөлгөөн хийгдэх зүгээр. Ийм хайрцгийг нь шахчхаж байгаа байхгүй юу. Хайрцгийг нь шахчхаж байгаа юм. Тэгээд 2 дугаар хэлэлцүүлэг дээр оролцохдоо хэдэн сайд нар нь баймаар байна. Салбарын сайд нар, дээрээс нь миний хүсэлт гаргах гээд байгаа Барилгын хөгжлийн төвийн даргыг байлгамаар байна. Хавдрын эмнэлгийн даргыг байлгамаар байна. Худалдан авах ажиллагааны газрын дарга ийм 3 хүнийг зайлшгүй байлгаж байж бид нар нэлээн сайн ярьж авахгүй бол 2, 3 дээр чинь шахагдчихдаг. Тодорхой зүйлүүд дээр гишүүдийн санал орж ирсэн саналаас чинь зөрүү гарчихвал нөгөөдхөө дахиад яах гэж сунгах гээд. Нөгөө 11 сарын 15 гэдэг хайрцагтаа шахаад зүгээр л орж ирснээр нь бараг дараад дараад явах ийм л юм руу явчих гээд. Тэгээд дээрх 3, 4 хүнийг зайлшгүй цуг байлгаач гэж би хүсэлт тавих гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Тэгээд эхлээд Тогтохсүрэн гишүүний 2 асуудлыг хойшлуулах асуудлаар санал хураалтыг явуулна. Ингээд энэ асуудал дэмжигдээд тодорхой дараагийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэгдэх тохиолдолд бас саяын Раднаасэд гишүүний хэлсэн холбогдох ажил эрхэлсэн албан тушаалтнуудыг байлгах талаас нь Байнгын хороо анхаарч ажиллая. Ингээд Тогтохсүрэн гишүүний гаргасан саналаар санал хураалтыг явуулъя.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлаас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 онд төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хойшлуулах, мөн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг мөн хойшлуулах гэсэн асуудлаар дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. 81,8 хувиар дэмжигдлээ. Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлыг 4 асуудалтайгаар баталлаа.

Ингээд 1 дүгээр асуудалдаа оръё. Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж 100 мянга гаруй иргэдээс ирүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэх талаарх нийтийн өргөдлийг хэлэлцэж эхэлье ээ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас 2023 оны 10 дугаар сарын 23 буюу өнгөрсөн 5 дахь өдрийн чуулганаар НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэхийг дэмжиж байна уу сэдэвтэй нийтийн өргөдлийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.1} дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын албан ёсны программ хангамж D-parliament платформын D-partition системээр дамжуулан гаргасан санал авах ажиллагааны үр дүнг Төсвийн

байнгын хороонд шилжүүлж ирүүлсэн байгаа. Ингээд санал авах ажиллагааны үр дүнг ирүүлсэн албан тоот болоод холбогдох материалыг бас та бүхэнд тараасан байгаа. Тэгээд энэхүү бас саналыг анх Төрийн бус байгууллага болоод мэргэжлийн холбоодуудын зүгээс санал гаргаж, Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар дарга ингээд нийтийн цахим платформд байршуулж ингээд 100 мянга гаруй иргэдийн саналыг ирүүлсэн байгаа. Тэгээд энэ санал авах ажиллагааны үр дүн болоод албан тооттой холбогдуулж тодорхой танилцуулга мэдээллийг бас Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар дарга хийнэ. Занданшатар даргын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтган мэндчилье.

Монгол Улсын Их Хурлаас дан системээр баталгаажсан нийтийн өргөдөл гомдлын цахим системийг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр нээлттэй нь хийж, дан системээр баталгаажсан 389 иргэн 453 нийтийн өргөдөл санаачилснаас шаардлага хангасан 48 нийтийн өргөдөл цахим системд нийтлэгдэн иргэдийн саналыг авч байна. Энэ нийт 405 өргөдлийн давхардал болгон агуулгаар нь авч үзвэл нийт өргөдлийн 50,6 хувь нь буюу 205 нийтийн өргөдөл нь нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлэхтэй холбоотой ийм давхардсан саналууд байсан.. Мөн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим СЕО клуб Монголын Үйлдвэрчний эвлэл зэрэг олон нийтийн байгууллагуудаас Улсын Их Хурлын даргад хандан Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хувь, хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтийг удаа дараа ирүүлснийг үндэслэн энэ саналуудыг нэгтгэж, 2020 оны 10 дугаар сарын 18-ны өдөр НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэхийг дэмжиж байна уу сэдэвтэй ПН20231070621 дугаартай

нийтийн өргөдлийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.1} дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын албан ёсны программ хангамж D-Parliament платформын D-Petition өргөдөл системээр дамжуулан гаргасанб

2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 16 цагийн байдлаар 6 хоногийн хугацаанд 101,817 иргэн уг асуудлыг дэмжин саналаа ирүүлсэн байх тул Монгол Улсын Их Хурлын Инновац цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 1 дүгээр тогтоолоор баталсан Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах санал авах журмын 4.1 дэх хэсэгт заасны дагуу санал авах ажиллагааны үр дүнг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна гэсэн албан бичгээр хүргүүлэгдсэн. Үндэслэл, тооцоо, судалгаануудын талаар ХАҮТ болон СЕО Клуб МҮЭ-үүдээс ирүүлсэн үндэслэлд олон улсын туршилагыг үндэслэн далд эдийн засгийг бууруулах татварын албанд мэдээллийг хуваалцах зорилгоор цахим хэтэвч болон төлбөр тооцооны хэрэгслийг шинээр амжилттай нэвтрүүлж, олон улсын туршилагыг нэвтрүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах и-баримтын олголтыг нэмэгдүүлэх замаар иргэдийн оролцоог хангах, и-баримтын шинэчлэлийг хэрэгжүүлэх, урамшууллын хувийг 50 болгож нэмэгдүүлж, сугалаа тохирлын урамшууллыг олгохгүй цуцалж, дижитал хэтэвч, дуу, дүрст чат, B2B, C2C зэрэг технологийн дэвшилүүдийг нэвтрүүлэх замаар бизнес, хэрэглэгчид, иргэдийн цахим технологийн дэвшилүүдийг нэмэгдүүлэх замаар хүрэх үр дүн бол өмнө нь Татварын ерөнхий газрын хийж байсан танилцуулгад үндэслэгдээд, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг 2023 онд нийт 829,99 тэрбум төгрөгийг буюу нэмэлтээр 497,99 тэрбумыг нэмэлт санхүүжилт шаардах боловч хууль мөрдөлтийг

сайжруулснаар төсөвт нэмж төвлөрүүлэх боломжит орлогын тооцоолол бол 534,35 тэрбум төгрөгөөр нэмэгдэх бололцоотой. VRRVAT revenue ration ДНБ-ий тооцоогоор 635,5 тэрбум төгрөгөөр тооцох бололцоотой гэсэн Татварын ерөнхий газрын тооцооллыг олон улсын валютын сангийн шинжилгээний аргачлалаар хийснийг бас ирүүлсэн болно.

Ийм учраас тооцоо судалгаа баримтууд болон холбогдох Монгол банк, Үндэсний статистикийн хорооноос гаргасан далд эдийн засгийн судалгаа и-баримтын олголтын судалгаануудыг холбогдох баримт хамт холбогдох байгууллагуудаас гаргуулан авч, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг бүрмөсөн хангах, энэ дотор байгаа булхай луйвар, авлига, хээл хахуулийн асуудлуудыг илчлэх замаар бол НӨАТ-ын орлогыг нэмэгдүүлэх бүрэн бололцоотой. Одоогоор татвараас зайлсхийсэн 620 хэрэг шалгагдаж байгаа. Авлига хээл хахууль, шударга бустай тэмцэхэд ч гэсэн ард түмний оролцоотойгоор и-баримтын шалгалтыг нэмэгдүүлж, энэ асуудлыг шийдвэрлэх нь эерэг нөлөөтэй гэж энэ байгууллагууд үзсэн. Эдгээр байгууллагуудаас бас ажлын хэсэгт оролцуулж, мэдээллийг авч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Мэдээлэл хийсэн Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар даргад баярлалаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 94 дүгээр зүйлийн 94.5-д Байнгын хороо энэ хуулийн 94.2-т заасны дагуу тухайн асуудлыг хэлэлцээд бодлогын баримт бичгийг боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх,

Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах эсэх асуудлыг шийдвэрлэж шаардлагатай гэж үзвэл санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан байгаа. Ингээд үүнтэй холбогдуулж байнгын хорооны зүгээс тодорхой энэ иргэдээс ирүүлсэн саналын хүрээнд энэ саналын дүнг үндэслэн татварын орчныг сайжруулах талаар холбогдох тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах саналыг та бүхэнд оруулж байна. Тэгээд Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тэгэхээр 1 талдаа иргэдээс санал гаргасан нь 100 мянган иргэд бас дэмжиж, өөрсдөө оролцож, саналаа дэвшүүлж байгаа нь 1 дүгээрт бол зарчмын хувьд би бас том дэвшил гэж харж байгаа. Иргэдийн оролцоо болоод саналыг бас гаргах платформыг Улсын Их Хурлын түвшинд бий болгож байна.

2 дугаарт 1 талдаа НӨАТ-тай холбоотой бас далд эдийн засаг байгаа тодорхой юу гэдэг юм НӨАТ төлөхгүйгээр тодорхой хэмжээнд 10 хувийн хөнгөлөлтийг эдэлдэг гэдэг юм уу, тодорхой далд зах зээл далд мөнгө байгаа нь үнэн гэдэг асуудал бас үүгээр гарч ирж байгаа. Энийг ч бас бүгдээрээ мэдэж байгаа. Нөгөө талдаа хувь хүнийхээ үүднээс харж байгаа өнцөг бас магадгүй энэ татварын ачаалал өндөр байгаагийн бас бодит илэрхийлэл байна уу даа гэсэн ийм асуудал байна. Тэгэхээр энэ асуудлын хүрээнд эдгээр асуудлуудыг иргэдээс гаргасан энэ саналуудыг судалж үзэх хүрээнд, яг холбогдох тооцоо судалгааг нь дүн шинжилгээг нь хийж тодорхой санал боловсруулах, нөгөө талдаа бүр нэмэгдсэн өртгийн албан татварын хэрэгжилтийг бүрэн хангуулж, хуулийн хэрэгжилтийг хэрхэн бид нар бүрэн дүүрэн хангуулж ноогдуулалт болоод төлөлт

тайлагналтыг нь хэрхэн сайжруулдаг болох вэ, иргэн бүр тэгш шударгаар хэрхэн төлдөг болох вэ, ил тод байдлыг хангах буюу далд эдийн засгийг ил болгох асуудлаар бол бас санал боловсруулах,

3 дугаарт иргэд, аж ахуйн нэгжүүдэд ер нь энүүгээр дамжуулж иргэд өөрсдөө бас илэрхийлж байгаа саналаа дэвшүүлж байгаа, өөрсдөө оролцож санал гаргаж байгаа асуудал маань магадгүй энэ татварын ачаалал бас хүнд байгаа асуудлыг дэвшүүлж байна гэж харж байгаа. Тэгэхээр иргэд, аж ахуйн нэгжүүдэд бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор НДШ зөвхөн НӨАТ биш НДШ, ХХОАТ болоод ААНОАТ зэрэг татвартай холбоотой нэгдсэн орчин татварын тогтолцоонд ер нь үнэлэлт, дүгнэлт хийгээд үзье. Энэ дээр дүн шинжилгээ хийе. Шаардлагатай бол татварын шинэчлэлийг бол Улсын Их Хурлаас, Төсвийн байнгын хорооноос санаачлаад энийг бас гаргаж тавья, танилцуулъя. Улсын Их Хурал болоод Байнгын хороондоо танилцуулъя гэсэн ийм саналыг бас та бүхэнд дэвшүүлж байгаа юм.

Тэгээд ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан. Миний бие бас өөрөө ахлах, энэ татварын шинэчлэл болоод тодорхой нэмэгдсэн өртгийн албан татварын далд эдийн засагтай холбоотой асуудлыг ил болгох, мөн энэ 100 мянган иргэдээс гаргасан саналыг судалж, тодорхой санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг бас өөрөө ахалж ажиллаж гэсэн саналтай байна. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух, тодорхой санал хэлэх, тайлбар авах, үг хэлэх гишүүд байна уу. Үг хэлэх болоод асуулт асуух гишүүдийн саналыг авъя. Пүрэвдорж гишүүнээр тасалъя. Сандаг-Очир гишүүнээр тасалсан.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Ардчилсан нам бол аливаа татвар, төрийн дарамтыг багасгах талаар

санаачилгатай ажилладаг. Тийм учраас мэдээж НӨАТ-ын татвар нь бол 10 хувь нь буураагүй, тэгэхдээ буцаан олголт нь 5 хувь болж байгаа энэ санаачилгыг дэмжиж байгаа. Тэгэхдээ 1 зүйлийг хэлэхэд НӨАТ-ын 10 хувийг багасгахгүйгээр энэ татварын бааз суурь нэмэгдэх асуудал ерөөсөө сайжрахгүй юм. Өөрөөр хэлбэл 5 хувь болгож байж л татварын бааз суурь нэмэгдэнэ. Нийтдээ 120 мянган идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгаа. Тэрний 80 мянга нь НӨАТ төлөгч байгаа. 40 мянгаас нь 5 хувь болгохгүй бол НӨАТ төлөгч болж нэмэгдэж орох нь бага байх. Дээрээс нь 250 мянган хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс байгаа. Тэрний 50 мянга нь л НӨАТ төлөгч байгаа. Үлдсэн 200 мянгаас нь 10 хувь байгаа тохиолдолд НӨАТ-ын төлөгч болж орж ирэх хүмүүс нь бас бага байх юм. Тийм учраас НӨАТ-ын 5 хувь болгох замаар өөрөөр хэлбэл НӨАТ-ын 5 хувь буцаан олголт нь 2 хувь, төлж байгаа нь 3 хувь. Энэ санаачилга, миний өргөн барьсан 2020 оны 5 сарын 24-нд өргөн барьсан энэ хууль бол илүү үр дүнтэй гэж үзэж байгаа.

Өөрөөр хэлбэл НӨАТ-ын татвар өндөр байгаа учраас анхнаасаа манайх өөрөө хэрэглэгч орон учраас Замын-Үүдээр ихэнх бараа бүтээгдэхүүнүүд орж ирдэг. Нэг том ачааны машин дээр хэдэн 100 нэр төрлийн бараа орж ирдэг. Тэр бараагаа анхнаасаа мэдүүлэхдээ л худлаа мэдүүлээд эхэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл юу байдаг юм цемент ч байдаг юм уу, аль эсвэл гурил ч байдаг юм уу нэг төрлийн бараа бүтээгдэхүүнээр бүрдүүлэлтээ хийгээд л плита ч юм уу оруулж ирээд, тэгээд түүнийгээ ингээд анхнаасаа бүрдүүлэлт нь буруу явчихаар Улаанбаатар хотын зах дээрх борлуулалт нь буруу явчихна. Цаашаа аймаг, сумд руу бүгдээрээ буруу явна. Тэгээд бүх хүмүүс анхнаасаа тэр нөгөө анхны оруулж ирж байгаа импортоор оруулж ирж байгаа тэр борлуулагчаас өгсүүлээд хамгийн сүүлд сум дээр борлуулж байгаа тэр хүртэл бүх бараа

бүтээгдэхүүний борлуулалт үйлчилгээ чинь бүгдээрээ худлаад яваад байгаа байхгүй юу даа. Тийм учраас татварыг багасгаж байж анхны тэр бүрдүүлэлтийг нь зөв хийж эхэлсний үр дүнд хүмүүс 3 хувийн татвар төлөх юм чинь 2 хувь нь буцаалт 5 хувийн НӨАТ төлнө, 2 хувь нь буцаалт 3 хувь нь төлөх учраас анхнаасаа зөв бүрдүүлэлтээ хийгээд явчихъя гэдэг ийм эх сурвалжаас бүх зүйл нь зөв болоод явна гэсэн л ийм л тооцоололтой байгаа. Ингэсний үр дүнд татвар бага байхаар НӨАТ-ын төлөгч нь ихэснэ, татварын бааз суурь нь нэмэгдэнэ. Татварын бааз суурь нэмэгдсэний үр дүнд дээрээс нь тэр их бараа бүтээгдэхүүн бүгдээрээ яг тэр худалдаа үйлчилгээний үе шат болгон нь ил тод болсны үндсэн дээр бусад татвараа бүрэн тооцоолж авах ийм боломж бүрдсэний үр дүнд төсвийн орлого чинь ерөөсөө буурахгүй ээ л гэдэг ийм тооцоолол гарсан байгаа.

Тэгэхдээ яг энэ өнөөдрийн Занданшатар даргын санаачлаад иргэдээс санал авсан энэ хуулийн төслийг Ардчилсан намын бүлэг ярилцаад, хэлэлцээд дэмжихээр ийм бүлгийн шийдвэр гарсан байгаа. Тэгэхээр бид нар энэ.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний микрофоныг 1 минутаар нэмье.

Б.Пүрэвдорж: Ардчилсан намын бүлэг хуулийг дэмжихээр шийдвэрлэсэн. Тэгэхдээ хэлэлцэх явцадаа бидний өргөн барьсан НӨАТ-ыг 5 хувь болгох буцаан олголт нь 2 хувь төлөх хувь нь бол 3 хувь байх энэ хуулийн төслөө хамтатгаад хэлэлцээд явах нь зүйтэй гэдэг ийм шийдлийг гаргасныг хэлье. Тийм учраас энэ хуулийг хэлэлцүүлэх явцад бас ажлын хэсэгт ороод ажиллах боломжтой шүү гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын даргаас санал, санаачилга гаргаад түүнийг иргэд бас дэмжсэн юм байна. Тэгээд одоо энэ чинь Байнгын хороо дээр тэгээд нэг ойлгомжгүй байдал үүсчхээд байна шүү дээ. Одоо ингээд 11 сар гарчихлаа. Төсөв батлах хуулийн хугацаа бид нарт 14 хоногийн хугацаа байна. Тэгээд хуулийн төсөл орж ирсэн юм уу гэхээр хуулийн төсөл орж ирээгүй. Тэгээд яг яана гээд байгаа юм. Төсвийн байнгын хороо хэлэлцээд хуулийн төсөл боловсруул гэх юм уу, эсвэл энэ тал дээр судлах ажлын хэсэг гаргах тогтоол гаргая гэж ажиллах юм уу. Төсөв өргөн баригдчихсан байж байдаг. 2 дахь хэлэлцүүлэг болох гэж байдаг. Тэгээд энийгээ бас нөгөө удирдлагуудын хэмжээнд яриад, эсвэл цаашидаа ер нь ингээд НӨАТ-ынхаа 10 хувийг 5 хувь болгоно гэх юм уу, эсвэл буцаан олголтоо 5 хувь. Энэ хуулийн төслөө боловсруулаад, тэр хууль тогтоомжийнхоо хуулийн дагуу оруулж ирээд ингээд Их Хурал дээрээ Төсвийн байнгын хороогоороо дамжуулаад хэлэлцээд явбал нэг өөр хэрэг. Гэтэл зүгээр иргэдээс санал авчхаад одоо энийгээ та нар шийд гээд Төсвийн байнгын хороо дээр ингээд асуудлыг оруулж ирээд гишүүдийг дунд нь ингээд 2 талцуулаад, Их Хурлыг 2 талцуулаад ингээд ийм ойлгомжгүй байдал үүсэж байгаа. Мэдээж ард иргэд бол татварыг хөнгөлөх гэдэг юм уу, буцаан олголтыг нэмэгдүүлэх гэдэг юм уу энэ чиглэлээр санал асуулга авбал 100 байтугай хэдэн мянгаараа ч дэмжинэ. Татварыг нэмэгдүүлнэ гэвэл хэн ч дэмжихгүй. Ойлгомжтой асуудал. Тийм учраас өнөөдөр Төсвийн байнгын хороо дээр чинь тэгээд бид нар яах ёстой юм. Энэ чиглэлээр эсвэл энийг нь илүү нарийн НӨАТ-ын буцаан олголтыг гэдэг юм уу, далд эдийн засгийг ил болгох чиглэлээр тооцоо судалгаа хийнэ гэдэг юм уу, энэ аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдийн татварын тайлан, оногдуулалт, бүрдүүлэлт энээ тэрээ юмыг судлах үүний дараа төсөвт ямар эерэг болоод сөрөг үр дагавар гарч болох юм. Ингээд

шийдлээ гэхэд бид нар өнөөдөр боогдчихсон төсвөөрөө хэрвээ 5 хувь болговол 500, 600 тэрбум төгрөгийн эх үүсвэр дутна шүү дээ. Энийг тэгвэл хаанаасаа олж ир гэж байгаа юм. Батлагдаж байгаа орж ирсэн хөрөнгө оруулалтаа хас гэж байгаа юм уу. Үндсэндээ л тэгж байгаа байх л даа. Хөрөнгө оруулалтаа хас гэж. Тэгээд үндсэндээ өнгөрсөн 4 жилийн чинь 2, 3 жил нь үндсэндээ бараг ковид гээд бүх л зүйлийг ковид руу төсвийг зориулсан байгаа, баталсан байгаа. Өнгөрч байгаа 2023 онд бол шинэ хөрөнгө оруулалт огт байхгүй. Ингээд Засгийн газрын оруулж ирсэн саналуудыг ингээд Их Хурал дэмжээд явчихсан байгаа юм. Тэгээд энэ жил нэг төсөв жоохон гайгүй болоод, орлого юм гайгүй биелээд, том эдийн засгийн утгаараа эдийн засгийн өсөлт сайжраад, ингээд нэг цалин тэтгэвэр нэмэх бололцоо боломж үүсээд, хөрөнгө оруулалт жоохон хийх нөхцөл бололцоо үүсээд ирэнгүүт ингээд хөрөнгө оруулалтаа хасаад НӨАТ-ын буцаан олголтыг нэмэгдүүл гэж байгаа нь өөрөө бас цаг үеийнхээ хувьд хэр оновчтой байна вэ. Энэ бол бас зүгээр 10 сарын 17, 18-аас эхлүүлээд ингээд хийчих богино хугацаанд ингээд шийдчих асуудал биш юм биш үү. Энийг нэлээн тооцоо судалгаа дээр хийхгүй бол эрдэмтэн, судлаачдын санал хүсэлтийг авахгүй бол иргэд олон нийтийн хэлэлцүүлгийг хийхгүй бол одоо ёстой жинхэнэ иргэдийн саналаар саналуудыг авсан юм бол яг нөгөө Их Хурлын хяналт шалгалтын хуулиар нийтийн сонголт энэ тэрээ юмаа хийгээд энэ дээрээ эдийн засгийн тооцоо судалгаагаар танилцуулаад эерэг сөрөг үр дүнгээ ярилцаад ингээд тэр Хууль тогтоомжийн хуулиа бариад ажиллавал илүү. Тэрнээс одоо бол яг энэ жил 2024 оны төсвийг батлах энэ цаг хугацаа тулчихсан үед энд бол нэлээд.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуулт асуулаа. Тэгэхээр 1 талдаа иргэд санал гаргалаа. 100 мянга гаруй иргэдийн

саналыг Улсын Их Хурлын цахим д-платформоор авсан. Мэдээж иргэд тодорхой хуулийн төслөөр, тодорхой асуудлаар санал гаргах эрх нь нээлттэй асуудал. Эрх нь нээлттэй. Тэгэхээр бид нарын хувьд тухайн тэр асуудлыг судалж хуулийн хүрээнд мөн дээрээс нь таны яг хэлж байгаа шиг эдийн засгийн тооцоо судалгаагаар дүн шинжилгээг нь хийж байж, судалж байж энэ дээр тодорхой дараагийн шийдлийг гаргах үүрэг нь Улсын Их Хурал дээр байгаа гэж харж байгаа. Улсын Их Хурал болоод Засгийн газар дээр. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу зааснаар бол энэ асуудлыг Төсвийн байнгын хороонд шилжүүлэх, холбогдох харьяалах байнгын хороонд шилжүүлснээр цаашид хуулийн дагуу тус Байнгын хороо энэ асуудлыг хэлэлцээд бодлогын баримт бичиг боловсруулах гэдэг юм уу, бодлогын баримт бичгийг гаргах эрх бас олгогдсон байгаа. Эсвэл мөн дээрээс нь таны хэлж байгаа шиг хяналт шалгалт явуулах, олон нийтийн хэлэлцүүлэг хийж, сонголт хийж энэ асуудлыг нарийвчлан судлах бас эрх Байнгын хороо дээр байгаа. Дээрээс нь шаардлагатай тохиолдолд эсвэл тухайн тэр хуулийн хэрэгжилтийг нь хангуулах. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд тодорхой зөрчил байгаад байгаа бол, хэрэглэгчид нь хангагдахгүй байгаад байгаа бол, далд эдийн засаг үүнээс хуулийн зөрчлөөс үүдэж байгаад байгаа бол магадгүй энэ асуудлаар ч гэдэг юм уу холбогдох байгууллагууд нь Засгийн газарт үүрэг даалгавар чиглэл өгөх эрх бол бас манай Байнгын хороонд байгаа. Дээрээс нь яах вэ, мэдээж хуулийн төслийг бас байгуулж болно. Ажлын хэсэг. Ажлын хэсэг хуралдаад энэ дээрээс тодорхой шийдвэр гаргах ёстой. Энэ хувилбаруудаас сонгож. Тэгэхээр мэдээж хуулийн төслийг Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд ч боловсруулж болно. Засгийн газар ч боловсруулж болно. Угаасаа хууль санаачлах эрхтэй субъектүүд бол Засгийн газар, Улсын Их Хурал байгаад байгаа юм. Тэгэхдээ гол нь Хууль

тогтоомжийн тухай хуулийн хүрээнд тухайн тэр хуулийн төслийг боловсруулах, судлах, тодорхой бүрдүүлбэрийг хангаж, тооцоо судалгаа, дүн шинжилгээг нь сайтар хийж байж тодорхой бодлогын шийдвэрийг гаргах эрх нь бөгөөд үүрэг нь Улсын Их Хурал дээр байгаа гэж харж байгаа.

Нөгөө талдаа иргэд энэ саналыг гаргаж, тодорхой нэг талдаа өөрсдөө оролцож, энэ бодлогыг дэвшүүлж, энэ асуудлаар та бүхэн судал гэж дэвшүүлж байгаа нь бол би бас 1 дүгээрт сайн зүйл гэж харж байгаа. Тэгээд энэ бол нэг талдаа бас бид нар иргэдийн оролцоог хангаж, ардчиллыг бас хангаж байгаагийн нэг том дэвшлийн үзүүлэлт гэж харж байгаа. Тэгээд энэ дээр бол Байнгын хороо, ажлын хэсэг гаргаад энийг нь дараах хуульд заасан хувилбаруудаас судалж үзэж нухацтай тооцоо судалгаа хийж байж шийдлийг гаргая. Шаардлагатай бол бид нар энэ асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж, Улсын Их Хурал тогтоол болоод шийдвэрийн төслийг оруулж шийдүүлж болно.

Холбогдох Засгийн газарт бас чиглэл өгч хуулийн төслийг боловсруулах чиглэлийг бас өгч болно. Улсын Их Хурал өөрөө хууль тогтоомжийнхоо хуулийн хүрээнд судлаад энийгээ бас хуулийн төсөл боловсруулж болно гэж харж байгаа.

Нэмж тодруулах зүйл байж болно.

“Ажлын хэсэг байгуулах” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Асуулт, үг хамт байгаа.

Ажлын хэсэг байгуулах бүрэлдэхүүн дээр би санал авъя. Тэр дээр та бүхэн ярьж болно шүү. Тэгэхээр би хувь хүнийхээ үүднээс та бүхэнд бас нэг ийм саналыг оруулж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний тогтоолын

төслийг тараачихсан байгаа учраас. Ер нь бол 1 дүгээр асуудал хууль тогтоомжийн шаардлагыг ханган 100 мянга гаруй иргэдээс ирүүлсэн НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэх талаарх өргөдлийн дагуу иргэдээс гаргасан өргөдлийн асуудлаар болон татварын орчныг сайжруулах талаар холбогдох тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсугай гэж байгаа. Ажлын хэсгийг Байнгын хорооны даргын хувьд миний бие бас өөрөө ахлаад, энэ асуудалд бас ул суурьтай хандаж нухацтайгаар өөрөө хариуцаж орёе гэсэн ийм саналтай байна.

2-т ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Сангийн сайд Жавхлан сайдыг би бас байгаасай гэж хүсэж байгаа. Жавхлан сайдыг бас оруулах хүсэлтэй байна. Дээрээс нь манай Байнгын хорооны төлөөлөл болсон тодорхой бизнес эрхлэгчид болоод аж ахуйн нэгж байгууллагууд хувийн хэвшил ажиллаж байсан бас манай гишүүдийн төлөөлөл болох манай Өнөрболор гишүүн болоод Амартүвшин гишүүдийг би бас ороосой гэж хүсэж байгаа. Дээрээс нь сая санал хэлсэн манай Сандаг-Очир гишүүн болоод Батжаргал гишүүдийг мөн Батсуурь гишүүнийг гэсэн ийм 7 гишүүнийг бас оруулах саналтай байна. Тэгээд та бүхэн маань ажлын хэсгийн 7 гишүүний ийм саналыг Байнгын хорооны даргын хувьд та бүхэнд санал дэвшүүлж байна. Энэ дээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй холбоотойгоор саналтай гишүүд байна уу. Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Яг ийм агуулга бүхий хуулийг би бас өөрөө санаачилчихсан учраас ажлын хэсэгт орохгүй байсан нь дээр л дээ. Тэгэхээр ер нь бол нэг талдаа 100 мянган хүний гарын үсэг цуглуулчихлаа. Нөгөө талдаа бас Тэмүүлэн дарга сая хэлж байна. Их Хурлын гишүүн хууль санаачлаад,

татварын хуулийг өөрчлөх хууль санаачлаад явах боломжтой гэж байна. Тэгэхээр энэ дээр бол ажлын хэсэгт ч юм уу, аль эсвэл нэгэнт л иргэдээс санал авахдаа 5 хувь гээд тодорхой асуучихсан байхгүй юу. Буцаана. 5 хувийн буцаалт олгоно гээд. Тэгэхээр энэ дээр чинь хууль санаачлаад ороод ирэх энэ боломж нь бүрэн байна шүү дээ. Тэгээд энийгээ л хурдан хийх ёстой байхгүй юу даа. Юун тэр юу байдаг юм. Тэгээд хуулиа төслөө бичээд ороод ирэх тэгээд тэр дээр нь ажлын хэсэг байгуулаад явах ёстой байхгүй юу даа. Энийгээ хийгээд яв л даа. Тэгээд би бас нэг зүйлийг хэлсэн шүү дээ Их Хурал дээр. Өөрөөр хэлбэл 2024 оны төсөвт асуудал үүсгэх гээд байгаа бол энэ хуулиа хэлэлцчих. Тэгээд баталчих. Тэгээд 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжинэ гээд тавьчих л даа. Тэгэх юм бол энэ хууль дараагийн парламент 2025 оныхоо төсөв оруулахдаа энэ хуулиа бодолцоод оруулна. 1 дүгээрт.

2 дугаарт нэгэнт л одоо татварын хувь хэмжээ багасаж байна гэсэн үг шүү дээ. 5 хувь болгож байна гэдэг чинь. Татварын хувь хэмжээ багасаж байгаа тохиолдолд тодорхой хэмжээгээр татварын бааз суурь нэмэгдэнэ. Баталгаатай. Тийм учраас тэр 600 тэрбум төгрөгийн хоосон зай үлдэнэ гэдэг. Тэрийг бол татварын бааз суурь нэмэгдсэнээр л нөхөөд хийчих боломжтой. Тодорхой хувийг нь. Хүрэхгүй байж магадгүй тэгээд бусад зардлаасаа хасах ёстой байхгүй юу. Засгийн газрын хэрэггүй бусад зардлуудаас энэ жил нөгөө 2024 оны төсөв дээр маш их Их Хурлын гишүүд өөрийнхөө тойрогтоо дахин сонгогдохын тулд баахан хөрөнгө оруулалт тавьсан. Тэр мэрийгээ бүгдийг нь шинэ Засгийн газар нь гарч ирж байгаад төсвийн тодотгол хийгээд хасах боломжтой байхгүй юу даа. Ийм байдлаар бас дутагдлыг нь нөхөөд гаргаад ирэх боломжтой. Миний өргөн барьсан 5 хувь буцаан олголт нь 2 хувь төлөх нь 3 хувь энэ хуулийн төсөл бол ямар ч асуудалгүй тэр 600 тэрбумын дутагдлыг татварын

бааз суурь нь хангалттай өсөн нэмэгдсэний үр дүнд бол бүрэн төлөх боломжтой. Дээрээс нь энэ бараа үйлчилгээнүүд 100 хувь татварын хяналтад орсны үр дүнд бусад бүх орлогыг нэмэгдүүлэх замаар төсвийн орлогыг чинь бүр илүү нэмэгдүүлэх ийм тооцоолол гарсан байгаа гэдгийг хэлье.

Тэгээд ер нь бол иргэд бол тодорхой л асуусан. Тодорхой хүсэлт гаргасан. Өөрөөр хэлбэл 5 хувь. НӨАТ-ын буцаалт 5 хувь. Энэ дээр хууль бичээд ороод ирэхэд бол нэг өдрийн л асуудал шүү дээ. Тэгээд энийгээ хууль болгочоод тэгээд тэрнийх нь дагуу ажлын хэсэг гараад ингээд явбал илүү үр дүнтэй л гэж би та нарт зөвлөмөөр байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн санал хэллээ. Тэгэхээр иргэдээс гаргасан саналын хүрээнд энэ асуудлыг судлах тодорхой шаардлагатай тохиолдолд бодлогын баримт бичиг боловсруулж оруулж ирэх, зөвхөн энэ иргэдийн буцаан олголтын 2 хувийг 5 хувь болгохоос гадна 2 дахь нь бол НӨАТ-ын татварын бүрдүүлэлт болоод тайлагналтыг нь сайжруулах, хамрагдалтыг нь нэмэгдүүлэх, далд зах зээл байгаа бол тэрийг нь ил болгох асуудал бас тодорхой бодлогын санал танилцуулах, гуравдугаарх нь ер нь нэг талдаа төсөв гэдэг өөрөө бас бодлоготой байх ёстой. Татвар гэдэг бол өөрөө. Тэгэхээр бид тэр татварын харилцаа нэг талдаа зөвхөн санхүүгийн үүрэг хариуцлагаас гадна бид нар нийгмийн харилцааг зохицуулах үүрэгтэй гэж харж байгаа. Тэгэхээр энэ үндсэн дээрээ цаашид бизнесийн орчин болоод татварын орчныг дэмжих, татварыг бууруулах үндсэн дээр тодорхой судалгаа хийж, шаардлагатай татварын шинэчлэлийг бодлогын баримт бичиг болгож оруулж ирье гэсэн ийм саналын хүрээнд энэ ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг та бүхэнд оруулж ирсэн байгаа. Цаашид хувь хүнийхээ үүднээс гишүүдийн гаргаж байгаа саналуудыг бүрэн дүүрэн

дэмжиж байна. Энэ асуудлуудыг ул суурьтай судалж нухацтай шийдвэр, шийдвэрийн төслийг гаргаж оруулж ирье гэсэн ийм саналтай байна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Үгүй ээ, яах вэ. Ажлын хэсгүүд байгуулья гэж байна. Татварыг зүгээр үе шаттай бууруулах асуудлууд бол бодлогоор хийгдэх л ёстой байх. Түүнээс хойш ингээд төсөв өргөн баригдчихсан хойно буцаан олголт маягаар ингэж оруулна гэдэг бол өөрөө төсвийг бужигнуулсан бүтэлгүй алхам. Саяхан л Үндсэн хуульдаа төсвийг өргөн барьснаас хойш орлого зарлагын тэнцлийг хангая. Энэ төсвийг дэндүү бужигнуулаад байна гэсэн агуулгаар Үндсэн хуульд ортол асуудал оруулж байсан шүү дээ. Тэгээд одоо болохлоор төсөв өргөн баригдсан хойно 4, 500 тэрбум төгрөгөөр ингэж төсвийг хооронд нь бужигнуулбал төсвийн тогтворгүй байдал, ер нь хойшидоо буруу жишиг тогтоно. Төсөв чинь өөрөө тусгаар тогтнолын баталгаа шүү дээ. Хэрвээ төсвөө баталж чадахгүй бол Улсын Их Хурал өөрөө тардаг хүртэл ийм заалттай. Гэтэл ингээд төсөв өргөн баригдсанаас хойш 4, 500 тэрбум төгрөгийн ийм будилаан хийж, энэ нэг талаасаа хасагдана, нөгөө талаасаа тэр чинь хөрөнгө оруулалт. 2 зүйл байгаа. Хөрөнгө оруулалт бол газар дээр үлдэнэ. Бодитоор хэзээ нэгэн эрх ашгийг хэн нэгэн хангана. Буцаан олголт бол хэн рүү буцаж байгаа нь ч мэдэгдэхгүй, хаашаа буцаж байгаа нь ч мэдэгдэхгүй ингээд үр ашиггүй жорлон руу ороод л дуусна. Ер нь зүгээр үе шаттай татварыг бууруулна гэдэг энэ асуудал бол төрийн хар хайрцгийн бодлогоор явах ёстой. Энэ Эрүүгийн хууль, Татварын хуулийг иргэдээс асууна гэдэг бол байж болохгүй асуудал шүү дээ. Ер нь иргэдээс асуугаад хэлсэн зүйлийг нь биелүүлээд ингэж яаралтай оруулдаг байсан бол түгжрэлийг чинь ард түмэн 100 байтугай саяулаа санал хэлчихсэн шүү

дээ. 7 жил хэлээд байгаа шүү дээ та нарт. 1 сая иргэн, 3 сая иргэн түгжэрлээ янзлаач гээд ди-парламент руу чинь, бүх сайд руу чинь, бүх дарга нар луу чинь өдөр болгон л хэлж байгаа шүү дээ. Тэгээд тэр асуудлыг ярихгүй байж байж төсөв өргөн баригдчихсан хойно янз бүрийн байдлаар ингээд оруулж ирж байгаа нь бол төсвийн тогтворгүй байдал буруу жишиг тогтох ийм үйлдэл гэж бодож байна.

Ер нь зүгээр манай намын үзэл санаа бол хувийн хэвшлийг дэмжих, татварын бодлогыг үе шаттай бууруулах. Энэ зорилгоо бол биелүүлэхийн төлөө байнга сөрөг хүчин ч байсан эрх баригч хүчин ч байсан явна. Гэхдээ энэ дээр бол тусгай бодлогоор, эрдэмтдийн өнгөрсөн үеийг, ирээдүй үеийг тооцсон байдлаар татвар дээр хандахгүй бол буцаан олголт гэдэг бол буцаан олголт байгаа. Энэ бол нийтдээ ер нь хувийн хэвшлийг дэмжсэн, баялаг бүтээж байгаа хүмүүсийг дэмжсэн, бүр анхан шатад үйлдвэрлэл эрхлэж байгаа хүмүүсийг тэр багт, тэр сумд, тэр аймагт энэ төвлөрлийг задлах хэмжээнд ийм үйлдвэрлэлийг хийж байгаа, нэмүү өртөг бүтээж байгаа хүмүүсийн татварыг хөнгөлөх асуудал бол байна. Тэгэхээр төсвөө өргөн барьчихсан. Энэ чинь жаран хэдийн бүлэгтэй ийм ямар эвслийн Засгийн газар ч биш. Ойролцоо суудалтай ч биш. Ийм том Засгийн газрын үйл ажиллагаа төсөв баригдсан хойно ингээд бараг хагас их наядаар яригдлаг ийм байж болохгүй ээ. Байж бол болохгүй. Тийм учраас энэ ажлын хэсэг гаргана гэдэг нь өөрөө төсвөөр шийдэх биш, ирээдүйд ирэх үр дагаврыг одоо болж байгаа нөхцөл байдлыг судална гэсэн ийм байдлаар би ажлын хэсэг байгуулах гэж үзэж байгаа юм. Тэгэхээс өөр энийг энэ төсвөөр шийднэ гэсэн асуудал бол биш байх гэж ойлгож байна.

Г.Тэмүүлэн: Батсуурь гишүүн бас санал хэлчихлээ. Тэгэхээр ерөөсөө хэрэв энэ оных байна уу, Пүрэвдорж гишүүний

хэлж байгаагаар дараа оных ч байна уу төсөв дээр өөрчлөлт оруулж хэрэв энэ асуудлыг юу гэдэг юм тусгалаа гэхэд энэ бол хуулийн өөрчлөлтийн хүрээнд хийгдэх ёстой. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт орох ёстой. Хуулийн төсөл боловсруулах ёстой. Хуулийн төслийг хууль тогтоомжийн хүрээнд боловсруулах үүрэгтэй байгаад байгаа. Тэгэхээр бид нарын ямар ч тохиолдолд хуулийнхаа хүрээнд бол явуулах ёстой. Энэ ажлын хэсэг гаргаж байгаа маань бол бас яг таны хэлж байгаа асуудлуудыг бүх талаас нь нухацтайгаар судалж үзье. Иргэд санал гаргах эрх нь нээлттэй. Тэрийг аваад тухайлсан тэр асуудлаар нь судалгаа хийгээд тодорхой шаардлагатай бол бодлогын баримт бичиг боловсруулаад эргэж танилцуулж, оруулж ирэх энэ үүрэг бүхий л ажлын хэсгийг гаргаж байгаа гэдгийг эцэст нь хэлье.

Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн, дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд маань анхааралтай байгаарай. Ажлын хэсэг байгуулах санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Өнөрболор гишүүн сая төхөөрөмж нь ажигласангүй. Дэмжсэнээр тооцъё. Ингээд нийт санал хураалтад 12 гишүүн оролцоноос 8 гишүүн дэмжиж, тогтоолын төслийг баталлаа гэж хэлэх байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

11.16 цаг.

2 дахь асуудалдаа оръё. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай” асуудлыг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа.

Улсын Их Хурлын тухай хуулийн 25.5-д Байнгын хороо шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна гэсэн байгаа. Бид нар төсвийн шинэчлэлийн хүрээнд Тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж, тодорхой тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд босго шалгуур болоод тодорхой үүрэг хариуцлагуудыг нэмэгдүүлсэн. Энэ өөрчлөлтийг шинэ хууль эрх зүйн орчныг бий болгосон.

Ингээд би та бүхэнд тодорхой бас товч мэдээллүүдийг өгье. Тогтвортой байдлын зөвлөлийг байгуулах тухай 2017 оны 11 дүгээр сарын 14-нд Улсын Их Хурлын 69 дүгээр тогтоол гарч байсан. Ингээд тэр ондоо Тогтвортой байдлын зөвлөлийг баталж байсан байгаа. Ингээд энэ баримт бичгүүдийг үндэслээд одоо 2018 оноос хойш Төсвийн байнгын хороо, зөвлөлийн дарга, гишүүдийг Төсвийн байнгын хорооноос 2, Засгийн газраас 2, Монгол банкнаас 2 хүмсийг нэр дэвшүүлж, хараат бус 3 гишүүнийг гэж зохих журмын хүрээнд сонгон шалгаруулж, ингэж үйл ажиллагаагаа явуулж ирсэн юм байна. Ингээд 5 дахь жилдээ байж байгаа. Тэгэхээр бид нар нэг талдаа хуулийн хүрээнд Тогтвортой байдлын зөвлөлийг шинэчлэн байгуулах шаардлагатай болсон. Шинэчлэн байгуулахдаа сая 2023 оны 7 сарын 7-нд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт орсон. Шинэ босго шалгуур болоод нэмэгдсэн үүрэг хариуцлагын хүрээнд энэ шинэ Тогтвортой байдлын зөвлөлийг бас байгуулах шаардлага байгаа. Бид нар энэ хүрээндээ Монгол Улсынж илийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, улсын жилийн төлөвлөгөөний төслийг тогтвортой байдлын хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх улсын төсөвт үзүүлэх

нөлөөлөл, ачааллын талаар судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт төлөв байдлын таамаглалыг боловсруулах гэдэг шинэ үүрэг хариуцлагыг оруулж ирсэн байгаа. Хуучин бол Засгийн газар тэр дундаа Сангийн яам ганцхан төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж, түүндээ нийцүүлж төсвөө боловсруулдаг байсан. Энэ асуудлыг бид нар бас нэлээн өөрчилж, одоо бол төсвийн хүрээний мэдэгдлийг Эдийн засаг, хөгжлийн яам, түүнийг боловсруулахад нь Эдийн засгийн хөгжлийн яамыг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт төлөв байдлын таамаглалыг нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл боловсруулдаг байхаар ингэж нэмж үүрэг хариуцлагатайгаар бол оруулж ирсэн. Тэгэхээр энэ бол цаашидаа төсвийн тогтвортой байдлыг бий болгох, төсвийн хүрээний мэдэгдлийг 3 тал харилцан хамааралтайгаар бас боловсруулдаг байхаар ингэж оруулж ирсэн байгаа.

Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн төсөв боловсруулахад оролцох нэг бүрэлдэхүүн байгууллага болсон. Ингээд ирэх оны төсвийн жилээс эхэлж буюу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл төсвийн шинэ цаглаврын хүрээнд үйл ажиллагаа явуулна. Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулж жил бүрийн 3 сарын 15-ны дотор Эдийн засаг, хөгжлийн яамд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал болоод Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацаанд төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах үндэслэл болох мэдээллүүдийг бид бас хүргүүлэхээр заасан. Шаардлагатай бол хагас жилийн дараа буюу 8 сард бас дахиж нэмж хүргүүлэхийг ингээд хийсэн байгаа. Тэгэхээр одоо бид нар цаашидаа тогтвортой байдлын зөвлөл буюу Монгол Улсын нэгдсэн төсвийг хянаж байх ёстой, манаачийн үүрэг гүйцэтгэж

байх ёстой байгууллага маань зөвхөн юу гэдэг юм орон тооны бус байдлаар ажиллах бус орон тооны шинэ зөвлөлийг байгуулах, дарга, гишүүдийг нь илүү хариуцлагатай байж, хуучин 9 гишүүн байсныг нь 7 орон тооны гишүүдтэй, доороо ингээд тодорхой судалгааны нэгжтэй байхаар ингээд оруулж ирсэн. Одоо бид нарын танилцуулж байгаа асуудал маань бол Тогтвортой байдлын тухай хуулийн 16/1.2-т зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах хуулийн зохицуулалтыг бас хийж ирсэн байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал дээр хийгдэж байгаа бусад нээлттэй сонгон шалгаруулалтын хүрээнд эрх бүхий хариуцлагатай албан тушаалтнуудыг сонгон шалгаруулдаг шиг Шүүхийн ерөнхий зөвлөл болоод бусад шүүгчдийг шалгаруулдаг шиг хүн тус бүрээр нээлттэй сонгон шалгаруулалт явуулна. Ингээд Улсын Их Хурал энэ хуульд заасны дагуу томилж, чөлөөлөх үүрэг хариуцлагыг оруулж ирж байгаа. Хуучин бол Байнгын хороо байсан бол нэг шат бид нар томилгооных нь асуудлыг бас ахиулж Улсын Их Хурал дээрээс заавал ч үгүй сонсгож, нэр дэвшигч нарыг нь томилж, чөлөөлөх үндэслэлтэй болсон. Ингээд та бүхэнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг хүргүүлсэн байгаа.

Энэ асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу. Пүрэвдорж гишүүн бас нэг санал хэлж байгаа нь дэд хороотой ойрхон байх ёстой гэж байгаа юм. Бид нар дараагийн асуудал нь болохоор нөгөө нэг дүрмийн шинэчлэх байгаад байгаа юм. Тэр дээрээ бид нар нарийвчилж тусгаж өгөөд ингээд заагаад явж болно. Тэгэхээр дүрмийн ажлын хэсэг дээр бас анхаараад явах тэр асуудал дээр бас ярилцаад явах уу.

Тэгэхээр тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн алга байна. Өнөрболор гишүүн, Пүрэвдорж гишүүн.

Д.Өнөрболор: Төсвийн бодлого тогтвортой байх тухай асуудал энэ өөрчлөлтөөр төсөв тогтвортой байх үндэс нь төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгаад байгаа юм. Тэгээд энэ зөвлөлийг би бас хууль батлагдаж байх үед бол маш хараат бус, улс төрөөс ангид, гол нь олон нийтийн дуу хоолойг шууд хүргэж чадахуйц хэмжээний ийм мэргэжлийн бүтэц байх ёстой талаар бас нэлээдгүй саналыг бол илэрхийлж байсан. Тэгээд энэ бүтэц бүрэлдэхүүнийг сонгох ажлын хэсэг байгуулагдаж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ер нь төсвийн бодлого бол нийгэм эдийн засагтаа үр өгөөжөө өгдөг байх ёстой. Иргэдийн амьдралд бодит өгөөжөө өгдөг байх ёстой. Өр үйлдвэрлэдэггүй байх ёстой ийм төсөв байх ёстой. Тийм учраас энэ бүтэц бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах нэн ялангуяа энэ улс төрийн ангид байдлыг нь бол тэр үед баахан дуу хоолойгоо хүргээд үнэхээр барж чадаагүй. Тэгээд ер нь одоогийн яг бүтцээрээ хэвээрээ явах. Төсвийн Байнгын хорооны бүтцэд бол харьяалалтай ингээд явах юм байна лээ. Уг нь энэ зөвлөл маш ангид ийм мэргэжлийн бүтэц байх ёстой гэдгийг бас дахин дахин би хэлмээр байгаа юм. Тэгээд энэ ажлын хэсэг бол нэн ялангуяа энэ бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулахдаа 2000 оноос хойш төсвийн зардал бүтцэд ерөөсөө огт өөрчлөлт орж байгаагүй. Ер нь урсгал зардал нийт 70 гаруй хувийг эзэлж байдаг. Төсвийн хөрөнгийн зардал бол 20 орчим хувийг эзэлж байгаа. Тэгээд дотоодын нийт бүтээгдэхүүний 40 орчим хувьд хүрсэн байж байгаа нь өнөөдөр бусад өөр улс орнуудын тоон жишигээс харахад үндсэндээ хөгжлөөсөө шалтгаалаад 10-17 хувь л байдаг юм байна лээ. Тэгэхээр өнөөдөр төр ер нь ямар их нүсэр байгааг манай эдийн засаг дахь төрийн оролцоо маш их өндөр

байгааг бас харгалзан үзэж бүрэлдэхүүнээ сонгох нь их чухал байгаад байгаа юм. Тэгээд сүүлийн 15 жилийн хугацаанд бас манай төсөв бол ерөөсөө л өр үйлдвэрлэж ирсэн байж байгаа. 2018-2020 онд Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсан байдаг юм байна лээ. Тэгэхлээр энэ агуулгаараа ер нь цаашидаа бол энэ хуулийн өөрчлөлтөөр орж ирж байгаа 3, 4 шинэчлэлийг бүр реформын шинжтэй хийх ийм бүтэц бүрэлдэхүүн байхгүй бол үндсэндээ бас уламжлалт өнөөг хүртэл явж ирсэн арга хэлбэр алдагдалтай төсөвт баталж тийм ээ, ийм их өндөр зардалтай, урсгал зардалтай ийм төсөв цаашидаа үргэлжлэх боломжгүй юм. Тийм учраас энд иргэдийн дуу хоолойг хүргэж чаддаг, дээрээс нь бас тодорхой хэмжээгээр улс төрөөс ангид дуу хоолойгоо хүргэж чаддаг ийм мэргэжлийн баг ажиллах нь маш чухал байгаад байгаа юм. Тийм учраас энэ байгуулагдаж байгаа ажлын хэсэг тухайн бүрэлдэхүүн дээр тавьж байгаа сонгон шалгаруулалтынхаа босгыг тавьж байгаа шаардлагуудаа өндөрсгөж энэ асуудалд бол хариуцлагатай хандах нь зүйтэй байна гэдгийг би бас хэлэх гэсэн юм аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Өнөрболор гишүүн санал хэллээ. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр улсын төсөв өнгөрсөн жилийнхээс 31 хувиар зардал нь нэмэгдэж орж ирж байгаа юм. Тэгээд улсын төсөв зардал өсөөд байна гэдэг чинь хэт танхар төсөвтэй, дээрээс нь хэт данхар төртэй л болж байна гэсэн үг. Тийм учраас энэ дээр хаана хязгаарлалт тавих гэж оролддог вэ гэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо дээр зардлаа багасгаач ээ, өнгөрсөн жил гэхэд бид нар 315 төсөл арга хэмжээг царцаах юм бол 500-аад тэрбум төгрөг хэмнэх боломжтой гээд. Энэ жил би дөнгөж сая Төсвийн зарлагын хяналтын дэд хороог хуралдууллаа. Нийтдээ 241 төсөл арга

хэмжээг царцаах юм бол 927 тэрбум төгрөгийг хэмнэх боломжтой юм байна. Тэгээд тэр царцааж байгаа төсөв нь бол хэрэггүй төсөв огт биш. Тэгэхдээ яг өнөөдрийн нөхцөл байдал дээр тодорхой хэмжээгээр царцаагаад, хойшлуулах нь илүү үр дүнтэй юмаа л гэж хэлээд байгаа юм. Тэгэхээр нэг талдаа ингээд Засгийн газар данхайсан төсөв оруулаад ирдэг. Нөгөө талдаа Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл энэ байгууллагууд энэ үрэлгэн төсвөө багасгах талаар л үг хэлж олон нийтийн сонорт хүргэх анхааралд оруулах тэр ажлыг л хийх ёстой байхгүй юу даа. Тийм учраас Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бол Төсвийн байнгын хорооны доор байдаг ганц бүтэц байгаа. Тийм учраас сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргын хувиар намайг оруулж өгөөч ээ.

2 дугаарт нь нэг тодорхой санал байна. Өөрөөр хэлбэл нэг талдаа төсвийн тогтвортой байдлын зөвлөл чинь олон нийт болон эрдэмтэд мэргэдийн бүх судалгааг авчраад энэ чинь болохгүй байна аа гэдгийг л хамгийн гол нь тодорхойлж хэлж, зөвлөх үүрэгтэй ийм байгууллага. Тийм учраас яг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо бол бас сөрөг хүчний дангаараа бас удирддаг ийм дэд хороо байгаа. Энэ дэд хорооны даргын санал болгосноор 1 хүнийг нь тийшээ оруулах ийм эрхийг өгөөч ээ. Энэ чинь бас төсвийн тогтвортой байдлын зөвлөл чинь бас тодорхой хэмжээгээр сөрөг хүчний үүргийг бас гүйцэтгэх ёстой байгууллага байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн өмнөөс та нарын хөрөнгийг төлж байгаа тэр татварын хөрөнгийг бид нар зөв зүйлд зарцуулна аа л гэж энд амлалт өгч орж ирж байгаа ийм л албан тушаалтнууд шүү дээ. Тийм учраас мэдээж олонхоороо асуудал шийддэг эрх баригч нар бол хэт олонх байгаа энэ тохиолдолд бас зарим нэгэн юман дээрээ бас яг Төсвийн байнгын хороо санаачилга гаргаад тодорхой албан тушаалууд дээр

сөрөг хүчнийхээ үгийг хүлээж аваад шийддэг ийм зүйлийг хиймээр байна гэж хэлмээр байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн санал хэллээ. Би тэгээд саяын юун дээр бас тайлбар хэлчихье. Тэгэхээр ерөөсөө анх удаагаа бид нар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг Тогтвортой байдлын хуульд хуульчилж оруулж өгч байгаа. Хуучин журмаар зохицуулагдаж байсан. Одоо энэ хууль дээр юу тусгагдсан гэхээр саяын Өнөрболор гишүүн, Пүрэвдорж гишүүд маань бас яг анх төсвийн шинэчлэлийн хуулиудыг өргөн барихад өөрсдөө өргөн барьж хамтдаа санаачилж ингэж батлуулсан. Яг та бүхний тавьсан хүсэлтийн дагуу зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг өндөрсгөсөн байгаад байгаа. Одоо ингээд шинэ зөвлөл бол шинэ сонгон шалгаруулалтын хүрээнд, шинэ шаардлагын хүрээнд сонгогдоно. Энэ дээр бид нар нэг хийсэн зүйл нь яг сая Өнөрболор гишүүний хэлсэнчлэн сүүлийн 6 жилийн хугацаанд улс төрийн гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх гэдгийг хааж өгсөн байгаа. Тэгэхээр ямар нэг улс төрийн нам болоод улс төрөөс ангид байх энэ юуг нь хэлж өгсөн. Дээрээс нь бас онцолж бүр хэлж өгөх юм чөлөөлөгдсөнөөсөө хойш ч 6 жилийн хугацаанд аливаа сонгуульд нэр дэвшихгүй байхыг нь хориглож өгсөн байгаад байгаа юм. Тэгэхээр энэ юу харуулж байна вэ гэхээр ямар нэг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг улс төрийн индэр байгууллага болгохгүй байх, улс төрөөс хамаарлаас нь ангид байлгах зохицуулалтыг нь хууль дээр хийсэн. Одоо тэгэхээр хуульд тусгасан шаардлагаар явна. Дээрээс нь бид нар энэ хүн бол эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болоод түүнээс дээш зэрэгтэй байна гэсэн шаардлагыг бас тавьж өгсөн. Ингээд эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж олон улсад нэр хүнд бүхий эрдэм шинжилгээ, судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх гэж байгаа юм. Эсвэл

эдийн засаг, төсөв санхүү, мөнгөний бодлого, төсөв санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршилагатай байна гэсэн энэ шалгуурыг тавьж гаргаж ирж байгаа. Тэгэхээр бид нар энэ шаардлагынхаа хүрээнд явна. Сонгон шалгаруулах зөвлөл бас Өнөрболор гишүүн хэлж байна. Иргэдэд дуу хоолойгоо шууд хүргэж, төсвийн алдаа оноо хэлдэг байх гэдэг асуудлыг тавьж ирж байна. Энэ чинь бас яг бид бүхний хэлж байснаар хууль дээрээ тусгагдчихсан. Анх удаагаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөл одоо 9 сарын 1-ээс ирэх оны төсөв жил болгон 9 сарын 1-нд өргөн баригддаг болно. 10 сарын 1 биш. 9 сарын 1-нд өргөн баригдангуут 9 сарын 20 хүртэл 20 хоногийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл төсвөө бүрэн ямар нэг дарамт шахалтгүй хугацааны хайчинд орохгүйгээр үзнэ ээ. Ингээд 20-ны өдөр буюу эсвэл амралтын өдөр таарч байвал дараагийнх нь ажлын өдөр нь олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг тавьж гарч ирсэн байгаа. Тэгэхээр энэ бол нэг талдаа үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж зөвхөн юу гэдэг юм Төсвийн байнгын хороо Улсын Их Хуралд дүн шинжилгээгээ танилцуулах санал, дүгнэлтээ танилцуулах биш хамгийн түрүүнд олон нийтэд энийг хэвлэл мэдээлэлд танилцуулах үүргийг хуульчилж бас оруулж хийж өгсөн. Тэгээд бид нар анх удаагаа бас энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл төсвийн гол бодлогын баримт бичиг болсон дунд хугацааны бодлогын стратегийн баримт бичиг болсон төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад оролцдог, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт тооцооллыг бас гаргаж Засгийн газарт өгдөг үүрэг хариуцлагыг бол 3 сарын 15, 8 сарын 15 гэсэн 2 үечлэлтэйгээр хийж өгсөн байгаа. Энэ зөвлөл өмнө нь орон тооны бусаар явж байсан бол одоо орон тооны ийм бүрэлдэхүүн болж доороо судалгааны нэгжтэй болж ингэж институт болгож, төсвийн хяналтын

байгууллага болгож ингэж товойлгож гаргаж өгсөн гэдгийг 2 гишүүнийхээ саналтай холбогдуулж тайлбар мэдээллийг хэлье ээ.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор нэр дээр нь ингэе сая Пүрэвдорж гишүүн оръё гэж саналаа хэлсэн. Тэгэхээр Батсуурь гишүүн гаръя гэсэн санал хэлсэн. Ингээд зөвлөлийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг миний бие өөрөө ахалъя гэсэн саналыг оруулсан байгаа. Гишүүнээр нь Пүрэвдорж гишүүн, Батжаргал гишүүн гэсэн 3 гишүүнтэй байхаар оруулж байна аа. Өөр саналтай гишүүд байхгүй бол энүүгээр ингээд явъя. Санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Баталъя гэсэн санал томъёоллоор. 12 гишүүн оролцож 9 гишүүн дэмжин 75 хувиар дэмжигдлээ. Ингээд ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

11.32 цаг.

3 дахь асуудалдаа оръё. Мөн үүнтэй холбогдуулж бид нар бас 1 сарын 1-ээс өмнө төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг бас шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаад байгаа. Үүнтэй холбогдуулж ажлын хэсэг байгуулах асуудлыг бас авч хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан. Тогтоолын төсөл дээр дүрмийн ажлын хэсгийг ахлах ажлын хэсгийн ахлагчаар Сандаг-Очир гишүүнийг бас тавьсан байгаа. Манай Хуувь зүйн байнгын хорооны гишүүн. Ажлын хэсгийн гишүүдэд Одонтуяа

гишүүн болон Баделхан гишүүдийг тавьсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд алга байна аа. Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж 75 хувиар дэмжигдлээ.

11.34 цаг.

4 дэх асуудалдаа оръё. 4 дэх асуудал маань Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд анхны хэлэлцүүлэг байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн орж байх хугацаанд Төсвийн ажлын хэсгийн ахлагч, Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн дарга танилцуулна. Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга танилцуулга хийе. Тогтохсүрэн даргын микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их хурал 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлтэс хэлэлцэх эсэхийг нэгдсэн чуулганаар хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлсэн.байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо Байгаль орчны байнгын хороодын хурлаар холбогдох хуулийн төслүүдийг хэлэлцсэн.нийт 21 хуулийн төсөл8 тогтоолын төслийг Байнгын хороодоор хэлэлцсэн байгаа.байнгын хороодоор хэлэлцсэн болон ажлын хэсэг Улсын Их Хурлын даргын захирамжаар

17 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гараад ажилласан. Ажлын хэсэг мөн дагасан хууль дээрээ нэг бүрчилж ажиллаад зарчмын зөрүүтэй саналуудыг бэлтгээд байнгын хорооноос гарсан санал ажлын хэсгийн саналуудыг нэгтгэж редакц хийгээд ингээд зарчмын зөрүүтэй саналуудыг бэлтгээд өнөөдөр байнгын хорооны хуралд орлож оруулж байгаа. Нийт45 зарчмын зөрүүтэй саналуудыг Байнгын хорооны хуралд оруулж байна аа. Байнгын хорооны гишүүд та бүгдийг 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслийн талаарх тогтоолын төслүүдийг хэлэлцэж зарчмын зөрүүтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн даргад баярлалаа. Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд зарим хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцээд санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд ирүүлсэн байгаа. Байнгын хороодын дүгнэлтүүдийг гишүүдэд тараасан байгаа. Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 9 хууль, 4 тогтоолын төслүүдийг хэлэлцээд санал, дүгнэлтээ ирүүлсэн. Ингээд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн танилцуулахаар байгаа. Өнөрболор гишүүний микрофоныг өгье.

Д.Өнөрболор: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд

өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 19, 20-ны өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 10 дугаар сарын 25, 26-ны өдрүүдийн хуралдаанаараа хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлээгүй бөгөөд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүнд баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн танилцуулна. Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Н.Энхболд нар эдийн засгийн бүсчлэлийг хөгжүүлэх төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутагт ажиллах төрийн албан хаагчийн ажилласан жилийг дүйцүүлэн тооцохоор тусгасан зарчмын хувьд зөв эсэх, нягтлан бодогчийн албан тушаалын талаарх зохицуулалтыг тусгайлан хуульд тусган зохистой эсэх, дээрх асуудлыг холбогдох журмаар зохицуулах боломжтой эсэх, мөн газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын эрх зүйн байдлыг өөрчлөх шаардлагатай эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Энхболд Төрийн албаны тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан төсвийн байгууллага нь нягтлан бодогчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тухайн салбарын төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэлтэй адил байхаар тогтоож болно гэсэн заалтыг хасах талаар зарчмын зөрүүтэй санал гаргасныг Төрийн байгуулалттай байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хороо Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал аваагүй зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэгт явуулсан талаарх Төрийн байгуулалттай байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүнд баярлалаа. Сая Өнөрболор гишүүн Эдийн засгийн байнгын хороонд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал, дүгнэлтээ унисан. Эдийн засгийн байнгын хороо энд бас тус тусад нь дүгнэлтүүдээ ирүүлчихсэн байна. Ирээдүй өв сан, үнэт цаас, уул уурхай, гаалийн тариф, ААНОАТ төрийн болон орон нутаг, зөвшөөрөл, төр, хувийн

хэвшил Засгийн газрын хүрээний баталгаа гаргах Засгийн газарт чиглүүлэх тэр гээд бүх хууль болоод тогтоолын төслөөр тус тусад нь санал, дүгнэлт гаргачихсан юм байна. Түүрүүн Эдийн засгийн байнгын хороонд санал, дүгнэлт дүгнэлтийг төсвийн хуулиар унисан тул бусад хуулийн санал, дүгнэлтүүдийг унисанд тооцлоо.

Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн бас танилцуулна аа. Таныг микрофонд урьж байна.

Д.Өнөрболор: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд
ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Кадастрын зураглал Газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүнд баярлалаа. Ингээд Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсож дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх байгаа.

Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болоод бусад оролцогчоос асуулт асууж болно гэж заасан. Ингээд зүйл бүрээр хэлэлцэж эхлэхээс өмнө та бүхэнд бас Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Барсүрэнгийн Баасандорж. Баасандорж дарга байна уу. Дарга нарыг дуудаарай. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, Магнайсүрэн дарга байна уу. Байнгын хороо холбогдох дарга нарыг дуудаарай. Төрийн өмчийн дарга нарыг. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон

гүйцэтгэгч Цогтын Баярбат дарга байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Анандын Энхманлай. Энхманлай дарга байна уу. Энхманлай даргыг бас дуудаарай. Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ядамын Самбууням, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Баттулгын Дөлгөөн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яам, Инновацын бодлогын газрын дарга Түмэндэмбэрэлийн Золзаяа, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга Очиржанцангийн Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандан Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамъяншиаравын Дэлгэржаргал, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт Очиржавын Дөлгөөнтуул, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Дангаасүрэнгийн Отгонжаргал, Сангийн яамны Төсвийн

нэгтгэлийн хэлтсийн шинжээч Энхбаярын Цолмон, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Рэнцэндоржийн Хангал, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Энхболдын Цолмон, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн Нямдаваагийн Сансармаа гэсэн байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулж дууслаа.

Ингээд 1 дүгээр асуудалдаа оруулъя орѐ. Төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг төсөл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 7 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Раднаасэд гишүүн асуулт асууя гэж байна. Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Энэ 7.9 дээр орж байгаа өөрчлөлт чинь байна шүү дээ. Энэ дээр чинь яг ямар өөрчлөлт хийчхэв ээ. Мэргэжлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, сум тосгоны Эрүүл мэндийн төвийг нь хасаад хаячхаж байгаа юм уу бүр. Одоо хэрвээ тэгэх юм бол эд нар чинь аймаг өөрөө, орон нутгийн төсөв өөрөө дааж явах гээд байна шүү дээ. Зөв үү. Аймгийн нэгдсэн эмнэлгийн.

Г.Тэмүүлэн: Эхлээд 1 дүгээр зүйл явж байгаа. Гэхдээ Раднаасэд гишүүний сая асуусан асуулт нь 4 дүгээр зүйл буюу 7.9 дэх заалт юм байна. 6 дугаар асуудал. Санжаадорж хариулах уу. Санжаадорж хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Засгийн

газраас орж ирсэн төсөл дээрээ юу гэж оруулж ирсэн бэ гэхээр холбогдох одоо байгаа заалт маань ямар учиртай заалт вэ гэхээр дансны үлдэгдлийг нь төсвийн жил дуусахаар татахгүй гэдэг заалт байгаад байгаа юм. Одоогийн зохицуулалт нь бол зөвхөн эрүүл мэнд орчихсон. Эрүүл мэндийг бол бид нар тарифаар буюу 3 хүн эмчилсэн бол 3 хүний тарифаар өгчихдөггүй учраас он дуусахад бол татах нь бол зүйд нийцэхгүй болчихоод байгаа юм. Нэгэнт гүйцэтгэл нь гарчихсан учраас. Үүн дээр нь нэмээд гүйцэтгэлийн байгууллагууд гэж ерөнхий байдлаар Засгийн газраас бол оруулж ирсэн юм. Гэхдээ ажлын хэсэг дээр яриад гүйцэтгэлийн байгууллага гэхээр хэт ерөнхий болчихоод наана чинь маш олон төрлийн байгууллагууд орж ирэх гээд байгаа учраас боловсрол эрүүл мэндээр нь хязгаалъя гэдэг байдлаар санал нь орж ирж байгаа юм. Тэгэхээр зөвхөн боловсрол, эрүүл мэндийн гүйцэтгэлээр санхүүжиж байгаа байгууллагууд дээр дансны үлдэгдлийг нь оны эцсээр татахгүй ээ гэдэг ийм зохицуулалт байгаа. Тийм дансны үлдэгдлийг.

Г.Тэмүүлэн: Хангалттай гэж үзэх үү. Раднаасэд гишүүнд нэмж тодруулъя.

Ш.Раднаасэд: Наадах чинь сурагчийн амралтын хугацааг аймгийн дарга тогтоож байгаа юм уу, зөв үү. Үгүй ээ, үгүй ээ. Хөдөлгөх эрхийг нь яам эрхээ шилжүүлчихдэг байхгүй юу. Тэр сайд сайд нь хаана байна. Боловсролын яамныхан байна уу. Тэр хүүхдийн хоолны чинь мөнгөөр баяр тэмдэглэсэн аймгууд байна. Би мэдэж байна харин. Мэдэж байгаа учраас би яриад байна шүү дээ. Та нар одоо энэ дансны үлдэгдэл гэдэг чинь ерөөсөө тэр лүү аваачиж хийж байгаа байхгүй юу. Одоо хоолны мөнгө 1500 болохгүй байна. Яаж 3000 болгох вэ гээд тэр боловсролын сайд чинь энд яв гэж байгаа биз дээ. Тэгээд одоо ингээд дансны үлдэгдэл тухайн жилийн үлдэгдлээ ингээд өөрөө зарцуулах эрхийг

нь нээгээд өгчихөөр наадах чинь сургууль бүр ажиллах боломжийг нь нээгээд өгчхөж байгаа байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ. Ажлын хэсэг хариулах уу. Санжаадорж хариулах уу. Санжаадорж 3 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Раднаасэд гишүүний ажилтанд хариулъя. Энэ зохицуулалт нь бол өөрөө төсвийн жил бол 1 сарын 1-нд эхлээд 12 сарын 31-нд дуусдаг. Орцоор буюу тухайн байгууллагыг бол хэдэн ажилчинтай байгаа тэр ч жишээ нь Сангийн яамыг санхүүжүүлдэг тэр аргаар санхүүжиж байгаа. Орцоор санхүүжүүлж байгаа байгууллага дээр дансны үлдэгдлийг нь бол зарцуулаагүй үлдэгдлийг нь татаад нэгдсэн төрийн сандаа татаад, тэгээд ирэх жилийнх нь төсвийн дагуу бол санхүүжилтээ аваад явдаг. Гүйцэтгэлийн байгууллагын хувьд яадаг вэ гэхээр ямар хэмжээний гүйцэтгэл гарсан байна тэрнийх нь дагуу тарифаа авчихдаг учраас тэрийг зарцуулах эрхээр явж байгаа. Зарцуулалт дээр хяналт тавих асуудал нь бол аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, дүүргийн санхүү төрийн сангийн хэлтэс, Сангийн яам бол хяналт тавьдгаараа тавина. Зориулалтын дагуу зарцуулсан уу, үгүй юү, хэмнэлтийн тухай хууль зөрчсөн үү, үгүй юү гэдэг дээр бол хяналтаа тавиад явчих учраас бол энэ заалт дээр хамааралтай зүйл биш байгаад байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Саналуудыг уншиж танилцуулъя. Төслийн 1 дүгээр зүйл доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/59 дүгээр зүйлийн 59.3.5 дахь заалт:

“59.3.5.өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ.” Санал гаргасан ажлын хэсгийн гишүүн Тогтохсүрэн, Адышаа, Анужин, Аубакир, Бат-Амгалан, Батсуурь, Баярсайхан, Дамдинням, Оюунчимэг, Пүрэвдорж, Сэргэлэн, Туваан, Цогтбаатар, Цэрэнпунцаг, Энхболд, Эрдэнэбат цаашид “ажлын хэсэг” гэх. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчилж, тус заалтын 59.8, 59.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.8.Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс энэ хуулийн 59.3.5-д заасан итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийг сумын орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилна.

59.9.Энэ хуулийн 59.7, 59.8-д заасны дагуу орлогын шилжүүлгийг тодорхойлсны дараа орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн үлдсэн хэсгийг энэ хуулийн 59.3.1, 59.3.2, 59.3.3-т заасан итгэлцүүрээр тодорхойлно.” Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна. Санал хураалт. Санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 3 дахь заалт болгон өөрчилж, тус зүйлийн 60.2.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“60.2.10.энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ орон нутгийн хөгжлийн сан улсын төсвөөс олгодог юугаа бас л нөгөө хүн ам цөөтэй аймгууд нутаг дэвсгэрийн хэмжээ хасаад шилжүүлчихсэн юм уу өөр газар луу. Ингээд ам бүлээр нь ч юм уу ялгаварладаг нэг ийм юм ойлгогдлоо. Яамаар ч байдаг юм. Өмнөх 2023 оны төсвийг ярьж байхад Бат-Эрдэнэ гишүүнийг уурлаад байсан шүү дээ. Ж.Бат-Эрдэнэ Булганы гишүүн. Яагаад хамгийн багаар явдаг, яагаад энэ тоо хөдөлдөггүй гээд, энэ итгэлцүүр чинь өөрөө зөв юм уу, буруу юм уу гээд. Орж байгаа орлогоос нь өгч байгаа хэлбэр хэмжээ юмнууддаа биш байна. Энэ өөр зүйл байна гээд Сангийн сайдтай муудалцаад яваад байна шүү дээ. Одоо тэр чинь дээр засагдаж орж ирээд байгаа юм уу, эсвэл бүр нарийвчлаад хаячихаж байгаа юм уу.

Г.Тэмүүлэн: ажлын хэсэг хэн хариулах уу. 3 номер Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан бол эх үүсвэр нь өөрөө АМНАТ-ын төлбөрийн 10 хувь, дээрээс нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр өөрөө тэр чигээрээ, дээрээс нь газрын тосны нөөц ашигласны төлбөр ингээд ордог. Өөрөөр хэлбэл уул уурхайн эх үүсвэртэй байгаад байгаа бүгд. Улсын төсвөөс бол тусгайлан бол эх үүсвэр олгодоггүй ийм юм байгаад байгаа. Нөгөө талдаа энэ мөнгөө хуваарилахдаа анх яаж хуваарилж байсан бэ гэхээр 4 итгэлцүүрээр өгч байсан. Тэр нь 1 дүгээрт алслалт, 2 дугаарт хүн амын тоо, 3 дугаарт газар нутгийн хэмжээ, 4 дүгээрт нь эдийн засгийн чадавх тухайн аймаг, орон нутгийн ийм 4 үзүүлэлтээр өгдөг байсан юм. Тэгэхээр өөрөө энэ сан маань өөрөө уул уурхайгаас орж ирсэн орлогын эх үүсвэртэй байгаа учраас нөгөө талдаа уул уурхайгаа илүү их ухуулж байгаа аймгуудад илүү хуваарилах ёстой гэдэг ийм зарчмын

саналууд гарч байсан учраас энийг ноднин 2023 оны төсвийг бол хэлэлцэж байхдаа нэмэлт саяын 4 дээр бол итгэлцүүр орж ирсэн нь алслалт гэдэг итгэлцүүр нь бол Нэгжийн тухай хуулиар алга болоод, ингээд 3 итгэлцүүр нь үлдээд хүн ам, газар нутаг, тухайн орон нутгийн чадавх үлдээд дээрээс нь АМНАТ-аа хэдэн хувь төвлөрүүлсэн бэ. АМНАТ-д төвлөрүүлж байгаа оролцоо нь хэр их байна вэ гэдэг үзүүлэлт орж ирсэн юм байгаа. Энэ орж ирсэн юугаа бол илүү тодорхой болгож нарийвчилж оруулж ирж байгаа ийм асуудал бол байгаа. 2 дугаар зүйл дээр. Мөн дээрээс нь юу орж ирж байна вэ гэхээр аймагт нь 40 хувийг нь зарцуулах эрхийг нь, сумд нь яг ухуулж байгаа тухайн нутаг сумд нь бол 60 хувийг нь зарцуулах эрхийг нь олгох ийм зохицуулалт бол үндсэндээ Төсвийн тухай хууль дээр бол орж ирсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Санжаа энэ АМНАТ төлбөр бүрдүүлж байгаа уул уурхайтай аймгууд нийслэл дээр нийслэл, нийслэлийн 9 дүүргээс үндсэндээ бараг ганц Багануур дүүрэг л байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл чинь ерөөсөө дандаа аймаг, аймгийн сум гээд яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр Улаанбаатар хотод, Улаанбаатар хотын дүүрэгтэй яаж хуваарилагдах вэ. Яг адилхан хуваарилагдах уу. 60/40-өөр гэж ойлгож байна. Энэ дээр хариулж өгөөч. Тэгэхээр манай дээр илүү хуваарилагдана гэсэн үг үү.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хариулъя. Санжаадорж. Ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Нийслэл, дүүргийн хувьд яг саяын зарчим ижилхэн үйлчилнэ. Өөрөөр хэлбэл дүүрэгтээ 60

хувь, нийслэл дээр 40 хувь гэдэг зохицуулалт байгаа. Дээрээс нь дүүргүүдээс Улаанбаатар хотын хувьд ирэх жилийн орон нутгийн хөгжлийн сангаар авах хэмжээ нь 50 орчим тэрбум төгрөг байсан. Үүнээсээ илүү их тэр ашиглалт, ухуулж байгаа тэр дүүрэгт илүү их хуваарилах ийм зохицуулалт бол байгаа.

Г.Тэмүүлэн: Тайлбар хангалттай юу. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж ажлын хэсгээс гаргасан санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналаар нь санал хураах уншиж танилцуулъя.

4.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн байна. Ажлын хэсэг. Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай. 54,5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураах. Нэг санал байгаа.

5.Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 1 дэх заалтын 59.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“59.2.2.энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилна:

59.2.2.1.хүн амын тоо;

59.2.2.2.нутаг дэвсгэрийн хэмжээ;

59.2.2.3.ашигт

малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 4 дүгээр зүйл дээр 2 зарчмын зөрүүтэй саналыг гаргасан байна. Уншиж танилцуулъя.

6.Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон өөрчилж, тус зүйлийн 7.9 дэх хэсгийн “төсвийн” гэснийг хасаж, “гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэснийг “эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,5 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “3.1.2, 4.1.3-4.1.10-т заасан нийтээр тэмдэглэх баярын болон” гэснийг “3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 45,5 хувиар дэмжигдсэнгүй. Раднаасэд гишүүн санал гаргая.

Ш.Раднаасэд: Тогтохсүрэн гишүүн саад болоод сая санал хураалтад оролцож чадсангүй ээ. Уучлаарай. Дахиж санал хураалт явуулж өгөөч.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ. Раднаасэд гишүүний санал. Ингээд дахин санал хураалтыг явуулъя. Сая уншиж танилцуулсан 7 дахь санал байгаа. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. 63,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. 5 дугаар зүйл байхгүй байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ингээд Төсвийн тухай хуулийг хэлэлцэж дууслаа.

2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. 3 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Үгүй ээ, ажлын хэсэг энэ заалтыг хасаад ороод ирчихсэн байх юм. Улаанбаатар хотоос тухайн орон нутагт иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэж төрийн захиргааны албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан иргэнийг аймгийн төвийн сумдад 1 жилийг 1,3 жилээр, аймгийн төвөөс бусад сумдад нь болохоор 1 жилийг нь 1,6 жилээр ажилласан жилд тооцно гэсэн. Энэ Төрийн албанд орон нутагт ажиллахгүй хүн олдохгүй байгаа. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахтай холбоотой чухал заалт гэж би харж байсан юм. Тэгсэн чинь ажлын хэсэг дээр хасахаар оруулаад ирчихсэн байх юм. Тэгээд ажлын хэсэг дээр ямар асуудал яриад ингээд хасахаар оруулаад ирчхэв ээ гэдгийг ажлын хэсгийн даргаас асууя.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуултад хариулна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Энэ 23.9 гэдэг заалтыг ажлын хэсэг дээр яриад тэгээд хасах санал гаргаж байгаа. 1 дүгээрт энэ бол зөвхөн шатлан дэвших тогтолцоонд л хэрэгтэй гэж хууль санаачлагч оруулж ирсэн байгаа юм. Шатлан дэвших дээр. Өөрөөр хэлбэл зөвхөн дараагийн төрийн захиргааны дараагийн албанд очиход л хэрэгтэй болохоос биш ажилласан жилд юм уу, бусад зүйлд тооцогдохгүй. Цалин хөлстэй холбоотой зүйл дээр.

2 дахь нь төрийн албан хаагчдыг ингээж ялгаварлаж болохгүй байх гэж үзэж байгаа юм. Нэг сумд яг ижил түвшинд ажиллаж байгаа албан хаагчдыг нэгийг нь нэг жилээр нь явдаг нэгийг нь 1 жил 6 сараар нь явдаг, нэгийг нь 1 жил 3 сараар явдаг ийм төрийн албан хаагчдын дунд ялгавартай байдлыг бол бий болгож болохгүй ээ. Энэ бол харин өөр хэлбэрээр нь орон нутагт очих бололцоог хангаж өгөх ёстой гэдэг байдлаар ажлын хэсэг асуудалд хандаж, энэ заалтыг хасах санал гаргасныг ажлын хэсгийн гишүүдийн олонх дэмжиж өнөөдөр Байнгын хорооны хуралд оруулж байгаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Ингээд төрийн албан хаагчдыг ялгаатай үзэж болохгүй ээ гэдгээр ингээд хасаж байгаа юм байна. Тэгвэл орон нутагт чинь ажиллах боловсон хүчин тун ховор байгаа. Тогтооход тун ховор байгаа. Тэгэхээр өөр ямар хөшүүрэг байж болох вэ. Эдийн засгийн, нийгмийн, орчин нөхцөлийн тийм нөхцөл байхгүй байна. Тийм учраас орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл гээд өгдөг болсонд нь сайшаалтай байна. Гэх мэтчилэн өөр

ямар тэнд тогтоох барих ийм хөшүүрэг байна вэ.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Сандаг-Очир гишүүний асуултад ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн хариулна.

Д.Тогтохсүрэн: Энэ төсвийн хууль дээр бол 2 том арга хэмжээ явж байгаа.

1 дүгээрт ипотекийн зээл байгаа. Ипотекийн зээл хуучин бол 80/20-оор явж байсан. Нийт улсын хэмжээний ипотекийн зээлийн 80 хувь нь Улаанбаатар хотод, 20 хувь нь орон нутагт байсан. Харин энэ орж ирж байгаа төслөөр Засгийн газрын орж ирсэн төслөөр 50/50 гэж орж ирсэн. Ажлын хэсэг дээр ярилцаж байгаад орон нутгийг нэмэгдүүлэх ёстой гэж үзээд орон нутагт нийт ипотекийн зээлийн 60 хувь байя гэж үзэж байгаа. Тэгэхээр 1 дүгээрт бол ипотекийн зээл буюу орон нутагт орон сууц барих энэ нөхцөлийг дэмжиж байж тэнд төрийн албан хаагч ажиллах бололцоо бүрдэнэ гэж үзэж байгаа юм.

2 дахь юм нь орон нутгийн нэмэгдлийг бий болгосон. Орон нутгийн нэмэгдлийг аймгийн төв дээр 20 хувь, сум дээр ажиллаж байгаа бол 40 хувь болгож нэмэгдүүлж байгаа. Энэ бол 2 дахь том хөшүүрэг болно гэж үзэж байгаа юм.

3 дахь нь энэ жил Төрийн албаны хуульд өөрчлөлт орсон. Энэ өөрчлөлтөөр суманд ажиллаж байгаа ажилд орж байгаа төрийн албан хаагч дээр 50.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн даргын микрофоныг нэмж өгье.

Д.Тогтохсүрэн: Төрийн албаны хуульд орсон өөрчлөлтөөр сумд ажиллах төрийн албан хаагч дээр нөгөө 3 жил гэдэг шаардлага байсан юм. Ажилласан

жил тэр шаардлагыг өнгөрсөн жил байхгүй болгосон. Өөрөөр хэлбэл ажилласан жилийг байхгүй болгох, эсвэл нөгөө шалгалтгүй болгох ч юм уу ийм хэлбэрээр л төрийн албан хаагч ажиллах байдлыг тэнд ажиллуулна уу гэхээс биш яг зэрэг ажиллаж байгаа хүмүүсийг өөр өөр ялгавартай юм бол байж болохгүй гэж байгаа юм. Харин энэ удаагийн төсвийн хуулиар нэг сайн зүйл нь юу байсан гэхээр орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг ялгаваргүй болгож байгаа юм. Хуучин зарим нь орон нутгийн нэмэгдэлтэй, зарим нь нэмэгдэлгүй. Тэгээд энийг бүгдийг нь жигдэлсэн. Сумд л ажиллаж байгаа бол адилхан орон нутгийн нэмэгдэл авна. Сумд л ажиллаж байгаа бол бүгд жигд байх ёстой гэдэг ийм л зарчим барьж байгаа учраас энэ заалтыг ялгавартай байдал бий болгож болохгүй ээ гэдгээр нь хасаж байгаа юм.

Тэр байтугай орон нутгийн нэмэгдлийг улс төрийн албан хаагч нийтлэг үйлчилгээний албан хаагчийн хувьд өгнө гэж энэ хуульдаа оруулж байгаа.

Г.Тэмүүлэн: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. 2 саналыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 23.9, 23.10 дахь хэсэг, Тайлбарыг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 57.18 дахь хэсгийг бүхэлд нь хасах Санал гаргасан ажлын хэсэг. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал байна. Санал хураалт. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд гаргах гишүүд байна уу. 2 дугаар зүйл дээр Баттөмөр гишүүн саналтай байгаа юм байна. Зарчмын зөрүүтэй санал. Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Та бүгдэд өдрийн мэнд хүргэе. Төсвийн тусгай хяналтын дэд хорооноос надад нэг үүрэг өгсөн юм. Юу вэ гэхээр Тагнуулын байгууллагатай холбоотой асуудлаар, цалин хөлстэй холбоотой асуудлыг Төсвийн байнгын хороонд танилцуулах үүрэг өгөгдсөн юм аа. Энийг би уншиж танилцуулъя. Тусгай хяналтын дэд хороогоор Тагнуулын байгууллагын төсвийг хэлэлцэх явцад хууль хоорондын зөрчилтэй байдал үүссэнтэй холбоотойгоор гаргасан саналыг би танилцуулъя. Тагнуулын байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг тагнуулын арга замаар хангах зорилгоор гадаад тагнуул, сөрөг тагнуул, эдийн засгийн тагнуул, техникийн тагнуул, хилийн тагнуул, нууц ажиллагааны үйл ажиллагаа төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр кибер аюулгүй байдлыг хангах шифр харилцааг харилцааг эрхлэх, төрийн болон нууцын, төрийн нууцын албыг хамгаалах зэрэг аюулгүй байдлыг хангах хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ийм онцлогтой байгууллагыг бид мэднэ. Төрийн албаны нууцын тухай хууль Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 244 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад Тагнуулын байгууллагын төсвийн нууцын төсөв, төрийн нууцын маш нууц зэрэглэлд хамаардаг. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 22.3-д тагнуулын байгууллагын албан тушаалын цалингийн сүлжээ жишигийг Тагнуулын ерөнхий газрын даргын санал болгосноор Засгийн газар тогтооно гэж заасан. Гэвч Төрийн албаны тухай хуулийн 57.5-д доор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын

цалингийн хэмжээ сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үзсэн Засгийн газар тогтооно гэсэн бөгөөд 57.5.4 тагнуулын байгууллагын ажилтан гэж заасан байгаа нь Тагнуулын тухай хуулийн 22.3 дахь заалттай зөрчилдөж байгаа юм. Өөрөөр хэлбэл 1 хуульд тагнуулын байгууллагын цалин Тагнуулын ерөнхий газрын даргыг үндэслэн Засгийн газар тогтооно гэж. Нөгөө хууль дээр бол Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг саналыг үндэслэн Засгийн газар тогтооно гээд заачихсан байгаа. Иймээс дээрх 2 хуулийн зөрчлөөс улбаалан тус байгууллагын төсөвт цалингийн асуудлыг шийдэхэд хүндрэл учирч байгаа юм. Иймд хууль хоорондын зөрчлийг арилгах уялдааг хангах үүднээс Тусгай хяналтын дэд хорооноос Монгол Улсын 2024 онд Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд уг хуулийн 57.5.4 дэх заалтын “тагнуул” гэснийг хасах гэсэн саналыг оруулж байгааг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баттөмөр гишүүн санал гаргаж байна. Би томъёоллыг нь уншаад танилцуулъя.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн дараах зарчмын зөрүүтэй саналын томъёолол гээд. Төсөл дор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл” төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5.4 дэх заалтын “тагнуул” гэснийг хассугай.

1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн гарчгийн нэмэлт гэсний дараа өөрчлөлт гэж нэмэх гэсэн ийм саналыг Баттөмөр гишүүн гаргаж байгаа юм байна. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн асуулт асууя.

Д.Тогтохсүрэн: Би Их Хурлаас асуух уу. Манай Их Хурлынхан байгаа билүү. 57 дугаар зүйл нь бол хөндөгдсөн юм. 57.5 дугаар зүйл нь хөндөгдөөгүй юм. Дэгийн тухай хуулиар нөгөө хөндөгдсөн заалтыг л хөнддөг. Тэгээд яг энэ 57.4 дэх заалт бол хөндөгдөөгүй заалт байхгүй юу. 57.5 огт хөндөгдөөгүй заалт байхгүй юу. Засгийн газар оруулж ирсэн бол 57.18-ыг оруулж ирсэн байхгүй юу. Тэгэхээр хөндөгдөөгүй заалтыг хөндөж байна. Энэ болох уу. 57 хөндөгдсөн гэж ойлгоод байх шиг байна. Би бол ойлгохдоо 57 дотроо яг тэр хөндөгдсөн заалтыг л ярих ёстой гэж бодоод байгаа юм. Тэгэхээр 57.18 хөндөгдсөн байтал Баттөмөр гишүүний оруулж ирж байгаа заалт 57.4 орж ирээд байна. Б

Болох уу гэж би асууж байна. Хөндөж болно гэвэл дэмжье. Бид бол хууль зүйн хүрээндээ дэгийн хуулиа бол нарийн баримталж явах ёстой. Мэдээж Тагнуулын байгууллагад тэр цалингаа тогтооход хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллагаар дамжаад Төрийн албаны зөвлөлөөр дамжаад явах нь бол хүндрэлтэй байгаа, нууцын зэрэглэлтэй холбоотой асуудал учраас байгаа юм болов уу гэж бодож байна. Гэхдээ нууц гэдэг нэрийн дор зах замбараагүй цалин хөлс нэмэгдүүлэхгүй байх гэдэгт бол итгэж л байна. Тэр дээр би хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Хууль зүйн зөрчил үүсэх эсэх, хөндөгдөөгүй асуулт биш үү гэдэг асуудал байна. Их Хурлын Тамгын газраас хариулах уу. Үнэнбат дарга.

М.Үнэнбат: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Сая Баттөмөр гишүүн санал гаргахдаа бол Тусгай хяналтын дэд хороогоор уг асуудлыг ярилцаад тэгээд дэмжигдээд ингээд санал гаргаж байгаа гэж ингэж хэлсэн. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлээр бол тухайн хуулийн төсөл дээр гаргаж болох, гаргаж болохгүй гэсэн хүрээ хязгаарыг заасан байгаа. Тэгээд 40.1 дүгээр хэсэгт

анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр гаргахдаа бол зүйл, хэсэг, заалтыг үг хэллэгийг өөрчлөх, засварлах тухай санал дүгнэлт гаргахаар бол заасан байгаа. Төсвийн тухай хуулийг дагаж орж ирсэн хууль учраас 40.3 дээр буюу хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл дээрх хүрээ хязгаарыг хамаарахгүй гэсэн ийм зохицуулалт байдаг учраас бол саяын тухайд бол Баттөмөр гишүүний гаргаж байгаа саналыг бол яг Дэгийн хуулийн зөрчил гарахгүй гэж ингэж үзэж байгаа.

Г.Тэмүүлэн: Үнэнбат даргад баярлалаа. Баттөмөр гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ. Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “өөрчлөлт” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр. Санал хураалт 72,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

3 дахь хууль. Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр 1 саналтай байгаа юм байна. Саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “2025 онд 40, 2026 оноос 65” гэснийг “2025 оноос 65” гэж өөрчлөх. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

4.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгийн зүгээс хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр гаргасан зарчмын зөрүүтэй 1 санал байна. 1 саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “дуудлага худалдааны” гэж” гэсний дараа “,139 дүгээр зүйлийн 139.1.17 дахь заалтын “сонгон шалгаруулалтад” гэснийг “дуудлага худалдаанд” гэж” гэж, “зураасан” гэсний дараа “болон түүнтэй адилтгах” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэж дууслаа.

5 дахь хууль. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр

зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

б.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй нэг санал байгаа юм байна. Ажлын хэсгийн саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Тайлангаар баталгаажсан өмнөх жилийн албан татвар ногдох орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс хэтрээгүй нөхцөлд тухайн хувь хүн” гэснийг “Хувь хүн” гэж, 15.7

дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрхтэй албан татвар” гэснийг “Энэ хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх албан татвар” гэж,” 21 дүгээр зүйлийн 21.2.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “20.1-д” гэснийг “20.1, 20.4-т” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

4 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 саналтай байгаа юм байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 21.2.5, 25.1.6 дахь заалт, 27.1 дэх хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.16 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 15.6, 15.7 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 23 дугаар зүйлийн 23.17 дахь хэсгийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл тус тус дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

Найруулгын 1 саналтай юм байна. Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 20.4, 20.5 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалтын 23.17 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож 7 гишүүн дэмжиж, 63,6 хувиар дэмжигдлээ.

7.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Энэ саналаар санал хураалтыг явуулъя. Саналыг уншиж танилцуулъя.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт дэмжигдлээ.

8.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан

зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

9.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Найруулгын бас 1 санал байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.15, 22.5.16 дахь заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний

өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.5.17 дахь заалтыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 18 дугаар зүйлийн 18.13, 18.14 дэх хэсэг, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 20.2.4 заалт, 24.5 дахь хэсгийн дугаарын өөрчлөлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, мөн зүйлийн 26.15 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 18.13, 18.14 дэх хэсэг, 3 дахь заалтын 24.5 дахь хэсгийн “нийслэл,” гэснийг “нийслэлийн болон” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 22.5.15 дахь заалтын “цэс” гэснийг “цэсийн” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.15, 22.5.16, 22.5.17 дахь заалтуудын “тус тус хөнгөлнө.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэтэй холбогдуулж Сандаг-Очир гишүүн асуултад асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа дарга аа. Би түрүүнд асуулт асуух гэж байгаад хоцорчихсон байна. Яг энэ заалт дээр бол биш. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээр 22.5.15 дээр орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг нийслэлийн 3 дүүрэг, Дархан, Орхон аймгуудад 2024-2026 онд 50 хувиар, 2027-2029 онд 20 хувиар гээд энэ их сайн заалт байгаа юм. Гэхдээ энэ хууль амьдрал дээр хэрэгжихэд бас их хэцүү байгаа юм аа. Зүгээр Дархан Эрдэнэтэд бол бололцоотой байх. Жишээ нь манай Налайх дүүрэг дээр гэхэд ерөнхийдөө орон сууц шинээр баригдах бололцоо боломж их хомс болчихож байгаа юм. Яагаад гэхээр ТЭЗҮ, дулаан нь ерөөсөө тулчхаж байгаа юм.

Дулааны хүчин чадал нь тулчхаж байгаа юм. Тийм учраас ер нь цаашидаа бас хэдийгээр газар нь байгаа, бололцоо боломж нь байгаа, төвлөрлийг сааруулах хэмжээнд байгаа боловч энэ ингээд гоё татварын хөнгөлөлтийн заалт орж ирж байгаа боловч яг амьдрал дээрээ яг орон сууц барихад орон нутгууд чинь бас нөгөө дулааны хүчин чадал нь хүрэлцэхгүйгээс болоод техникийн нөхцөл өгөхгүй. Хэрвээ орон сууц барья гэвэл ерөөсөө л дэд бүтэц шүү дээ. Тийм учраас яг амьдрал дээрээ бас энэ заалт яг хэрэгжээд явахад бас учир дутагдалтай байгаа юм шүү. Тийм учраас цаашидаа бас наад зах нь Налайхыг дулааны станцыг нь өргөтгөх асуудлыг хийж байж, дэд бүтцийг нь тавьж байж. Ингэсний дараа энэ бодлого хэрэгжиж аж ахуйн нэгжүүд дээр явна. Багануур дүүрэг дээр гэхэд ойрын хэдэн жил бол техникийн нөхцөл бололцоо боломж байгаа. Энэ хуулийн хэрэгжилт бол хэрэгжээд явахад бололцоотой байгаа юм аа. Тийм учраас Багахангай, Налайх 2 дүүрэг дээр бол энэ хуулийн хэрэгжилт явахад бас их нэлээн хүндрэлтэй байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт 63,6%-аар дэмжигдлээ.

10.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс 1 дүгээр зүйл дээр зарчмын зөрүүтэй 1 саналтай байгаа уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “татварын хуульд зааснаас бусад” гэснийг “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.8-д, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 24.5-д зааснаас бусад”

гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

11.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй байгаа.1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс 1 зарчмын зөрүүтэй санал байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 10.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, тус зүйлд доор дурдсан агуулгатай 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.3.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд худалдах гэрээг байгуулахад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан гэрээг байгуулахдаа тухайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дундаж үнийг баримтална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй

санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

12.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Хөөш нөгөө нэг эмийн чанарын юм чинь юу болсон бэ. Худалдан авах журам чинь. Одоо энэ Чинбүрэн гишүүн хямд үнэтэй эм хэрэглэнэ ч гэнэ үү Хянан шалгах хороо гэж юм байгуулчихаад бас яваад байх юм. Энэ ер нь яг эрүүл мэнд, эмнэлгийн асуудал болохоор асар том лобби явах юм аа. Өвчин ярьж хүн бодох биш, өвчин ярьж мөнгө ярьдаг боддог тийм юм гарчхаад байх юм. Нөгөө нэг юм чинь журамдаа яг суусан уу. Нөгөө чанарыг нь харгалзаж үзнэ гэдэг юм. Аягүй бол хянан шалгах нөгөө хорооноос чинь бас үнийг нь буулгана гэдэг юм бас яваад байна уу. Энэ дээр би нэг тайлбар авъя. Тэгээд хуулийнхаа хэрэгжих хугацааг хойшлуулж байгаа юм байна тийм үү. 1 сараар. Уг оноос өмнө хэрэгжиж л байвал уг нь хэрэгтэй л юм байгаа юм даа. Тэгээд аймаг орон нутгийн 2 дахь шатлалын эмнэлгүүд чинь юу авч байгаа. Түрүүн нөгөө тэр төсвийн үлдэгдэл өөрсдөд нь харин үлдээхээр болгочхож байгаа юм. Энэ ингээд даатгалтай холбоотой эмийн хомсдолыг бий болгоно. Ийм эм байхгүй байна. Та гэрээсээ авчирч тариулбал тариул гэдэг. Тэгээд л хүмүүст өөр дээр нь дарамт үүсэх ийм нөхцөлүүдийг л улам бид нар нээж өгөөд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр хариулах хүн байна уу. Ер нь хэдүүлээ завсарлах уу. Яамнууд чинь хэдэн мэргэжилтэн үлдчихсэн байна шүү дээ. Ингэж суух ямар хэрэг байна.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. 1 номер Энхболд.

З.Энхболд: Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга Энхболд Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга 12 дугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр байгаа. Сангийн яамнаас холбогдох журам, заавар, жишиг баримт бичгүүдээ боловсруулаад, төсвийн ерөнхийлөн захирагчдаас саналаа аваад боловсруулаад явж байгаа. 1 эх үүсвэрээс худалдаж авахтай холбогдолтой журмын төслийг бол Эрүүл мэндийн яам боловсруулахаар байгаа. Эрүүл мэндийн яам бол эхний байдлаар драфтаа гаргаад, манай яаманд 1 дэх өдрийн байдлаар мэйлээр ирүүлчихсэн байгаа. Эхний байдлаар бид хэд мэйлээр саналаа явуулж байгаа явуулж байя, та хэд үзээд бас саналаа өгөөч ээ гээд боловсруулалтын шатдаа явж байгаа. Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөхөд холбогдох журмууд бол бүгд гарч дуусна.

Г.Тэмүүлэн: Энхболд нэмж хариулъя.

З.Энхболд: Гишүүний асуултад нэмэлт хариулт хэлье. Эрүүл мэндийн яам яг тэр 1 эх үүсвэрээс буюу Олон улсын байгууллага буюу эсвэл тэр үйлдвэрлэгчээс нь шууд худалдаж авах зохицуулалтын хүрээнд худалдан авах ажиллагааныхаа журмыг Эрүүл мэндийн яам боловсруулахаар бол хуулийн шинэчилсэн найруулга туссан байгаа. Энэ журмаа бол Эрүүл мэндийн яам боловсруулаад явж байгаа юм байна лээ.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг 1 саналтай байгаа саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 8.15 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.15.Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул-олборлолтын ажлыг хамтад нь гүйцэтгэх этгээдтэй арав хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулахаар тендер зарлаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

13.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчил худалдан авах тухай шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

14.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

15.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 5 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Раднаасэд, Сандаг-Очир гишүүнээр тасалъя. Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Дарга нараа дуудаарай дарга аа. Таны нэр хүндийн асуудал. Энд хариулах хүн байна уу Газрын тухай хуулиар. Төрийн өмчийн эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн газар дээр баригдсан хууль бусаар тогтоогдсон хэчнээн барилга байна. Та нар дээр. Яг шүүхийн шийдвэрээр тогтоогдчихсон. Би энэтэй чинь холбогдуулж тэр 48 дугаар зүйл дээр би өөрчлөлт оруулах гээд байна. Санал гаргах гээд байна. Та нарын өөрчилж өгсөн зарчмын зөрүүтэй санал дотор л лав явж байна. Түрүүн чинь заалт хөндөөгүй байхад зүйл хөндөж болно гэсэн биз дээ. Тийм 42 дээр. 42 хөндөгдсөн байна. Одоо энэ төв төв эмнэлгүүд байна. 3, 2, 1, Хавдрын эмнэлэг, Халдвартын эмнэлэг. Энэ эмнэлгүүдийн газар дээр баригдсан байшингууд шүүхийн шийдвэр гарсан бол төрийн өмч дээр барилгыг нь авдаг энэ юм руу оръё оо. Их сургуулийг тойрсон барилгууд байна. Техникийн их сургууль, МУИС, Анагаахын сургууль. Тэгж байж бид нар энэ газрынхаа хууль бус газартай холбоотой энэ юмнуудаа зогсоож

авахгүй бол голын эрэг дагасан 2, 3 байшин нураагаад юм гарахгүй ээ. Тийм учраас та нараас би өнөөдөр тоо судалгаа асуух гээд байна л даа. Яг хэчнээн эмнэлэг, хэчнээн сургууль, хэчнээн цэцэрлэгийн газар дээр хууль бусаар байшин барилга баригдсан бэ. Тоон статистик та нарт байх ёстой. Тэгэхээр 42.3 дээр би санал гаргаж бичиж оруулах гээд байгаа юм. 42 дугаар зүйл бүхэлдээ хөндөгдсөн учраас би 3 дугаар хэсэг гээд нэмэх гээд байгаа байхгүй юу. Тэгээд зүйл хөндчихсөн байна заалт хөндөж болно. Түрүүн Их хурлын Тамгын газрын дэд дарга чинь орж ирээд болно гээд хуулийн заалт уншихаа биз дээ.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Энхманлай дарга хариулъя. Энхманлай даргын микрофон өгөөрэй.

А.Энхманлай: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Газрын хуулийг хэрэгжүүлэх, тэр дундаа төрийн өмчийн газруудыг бүртгэлжүүлэх тооллого хийх энэ ажлыг бас манай яам дээр ажлын хэсэг байгуулагдаад зохион байгуулж байгаа. Ер нь бол сая ярьсан сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газруудаас хууль бусаар газар олгосон судалгаануудыг бол бүрэн гаргасан. Эмнэлгийн тухайд 6 эмнэлэг дээр бол хууль бус газар олгогдсон гэсэн ийм судалгаа гарсан. Энэ ажлын хүрээнд зарим нэг шүүхийн шийдвэрүүд гарсан, шүүхийн шийдвэрүүдийг бас хэрэгжүүлээгүй байгаа газрууд дээр бол холбогдох Засаг дарга нар луу бол албан тоот хүргүүлсэн. Энэ бол нийслэлийн тухайд ярьж байгаа. Тэгээд бас энэ дээр бол бид бүхэн бол цаашидаа сургуулийн газрууд дээр, мөн цэцэрлэгийн газрууд дээр ч гэсэн энэ ажлуудаа үргэлжлүүлээд зохион байгуулаад явна. Ер нь бол Газрын тухай хууль дээр мөн төрийн өмчийн газруудыг цаашид шилжүүлэхгүй байх, өөр зориулалтаар ашиглуулахгүй байх талаар бол бас эрх зүйн зохицуулалт орж өгсөн. Ингэснээр бол харин газар цаашид бол өөр зориулалтаар бусдад

шилжихгүй байх ийм боломж бүрдсэн ийм нөхцөл байдал болсон байгаа.

Тэрийг бол яг одоо санахгүй байна. Танд биечлэн бас бичгээр хариу тайлбарыг өгье.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Газрын тухай хууль дээр та бүхэн маань бол Засгийн газраас өргөн барьсан чинь бол ерөнхийдөө аймаг, нийслэл, сум дүүргийн газар олголтыг бол үндсэндээ яам дээр олгохоор оруулж ирсэн тийм үү. Тэрийгээ ажлын хэсэг хассан юм байна. Гэхдээ орон нутагт газрын асуудал, газрын мафитай асуудал, тэр дундаа нийслэл Улаанбаатарт байгаа юу байгаа. Та бүхний санаа бол яах вэ, ер нь бол газрын замбараагүй олголтыг цэгцлэх гэж л оруулж ирсэн санаа чинь энэ. Тэгээд энэ дээр ингээд Засгийн газар, Их Хурал дээр ажлын хэсэг дээр ингээд энэ чинь хасагдаад явж байна. Ингэснээрээ асуудал шийдэгдэхгүй л дээ. Одоо ганц мөрдөхгүй байгаа юм чинь аймаг, нийслэлийн хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө. Ерөнхий төлөвлөгөөгүй ч аймгууд яваа шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Хэсэгчилсэн гээд нэг төлөвлөгөөнүүд байгаа байх. Тэгээд цаашидаа ер нь газар олголтыг сум, дүүрэг, газар олгож байна. Аймаг, нийслэл газар олгож байна. Яам газар олгож байна. Энэ бүх шатанд газар олголтыг яаж цэгцлэх гээд байгаа юм. Энэ бодлого чинь ингээд та нар яам дээр цэгцэлж чадахгүй. Та нар сумын Засаг дарга дээр, дүүргийн Засаг дарга дээр газар олголтын чиглэлээр ямар их өргөдөл хүсэлт байдгийг мэдэхгүй. Тэгээд танай яам ямар хүний нөөцтэй билээ. 21 аймаг, 9 дүүргийн газар олголтыг та нар нэгтгээд олгоно гэж энэ бодлого чинь бол хэзээ ч бүтэхгүй. Улам их иргэдийн өргөдөл гомдол чирэгдэл улам их ачаалал нэмэгдэнэ. Та нар урдах ажлаасаа гарч чадахгүй болно. Тэгээд л эрх шилжүүлэх асуудлууд. Тийм

учраас цаашидаа ер нь газар олголтын замбараагүй байдлыг ер нь яаж цэгцлэх гээд байна. Энэ Барилга, хот байгуулалтын яам. Энэ олон газар олголт давхцал газар олголтуудыг яаж цэгцлэх гээд байна. Манай Налайх дүүрэг дээр л гэхэд Тэрэлжийн байгалийн цогцолборт газар. Үнэхээр замбараагүй, гишгэх газаргүй, яамнууд нь газар олгочихсон. Дүүрэг нь газар олгочихсон. Нийслэл нь газар олгочихсон. Давхардуулаад олгочихсон хүний хашааг тойруулаад оргочихсон. Гарцыг нь хаагаад газар олгочихсон гээд ямар ч тийм төлөвлөлт байхгүй. Төлөвлөлтийнх нь дагуу болгоно гэхээр төлөвлөлт нь тэгж хийгдсэн байдаг юм уу. Тийм төлөвлөлтийг бас баталж байдаг юм уу яам, Засгийн газар нь. Тийм учраас яам танайхан цаашидаа газар олголтоо ер нь яаж цэгцэлье гэж бодоод байгаа юм бэ. Энэ дээр та бүхэн хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Хариулт өгье. Сандаг-Очир гишүүний асуултад. 7 номер Баярбат Төрийн нарийн бичгийн дарга.

Ц.Баярбат: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярбат Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Төсвийн тухай хууль дагалдуулж оруулж ирсэн Газрын тухай хуулийн 8.1.10 дээр бол Засгийн газрын төлөвлөгөөний дагуу хяналт тавихтай холбоотой заалт байсан маань ажлын хэсэг дээр хэлэлцэгдээд хасагдсан байгаа. Гэхдээ бодлогын хувьд бол бид нар ийм бодлого барьж байна. Бүх газруудыг хянахад бид нар бүх бүх юмаа цахимжуулж байгаа. Цахим системд оруулж байгаа. Энэ цахим системд бүх батлагдсан төлөвлөгөөнүүд орно. Тэрний дагуу орон нутаг, аймаг, нийслэлийн хэмжээнд газар олголтыг хэрхэн зохион байгуулах вэ гэдгээ хянахаар ингээд орчихсон байгаа. Энэ цахим систем дотор бол газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөнүүд

бол бүгд орж байгаа. Энэ хяналтыг бол Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар маань хийгээд явна. Ер нь газрын асуудлыг нэгдсэн бодлого төлөвлөлтөөр хэрэгжүүлэх үүднээс бол Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар бол Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж байгаа. Тэгэхээр манай яамны эрхлэх асуудлын хүрээнээс хасагдаж байгаа. Энэнтэй холбоотойгоор Засгийн газрын тухай хуульд бас нэмэлт, өөрчлөлт орж ингэж өөрчлөгдөж байгаа. Тэгэхээр цаашид бол Ерөнхий сайдын дэргэд агентлаг ажиллаж, энэ төлөвлөлт, хэрэгжилт бүх юмнуудаа зохион байгуулж явах ийм болж байгаа. Түүнээс гадна бас энд бид нар Газрын тухай багц хуулийн төслийг удахгүй Улсын Их Хурлын намрын чуулганд өргөн барих ийм төлөвлөгөөтэй байна. Энэ дээр бол түрүүний хэлсэн холбогдох нэгдсэн төлөвлөлтийн дагуу газар олголтыг хийх, цаашид нэгдсэн бодлого барьж ажиллах, бүх орон нутаг нийслэлийн хэмжээнд энийг бол энэ хуулиар зохицуулалтуудыг нь шинээр томъёолж орж ирэх ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна аа.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Газар олголтыг цахимжуулах гэж байгаа гэж байгаа чинь бол сайн байна. Цахимжуулмаар байна нээрээ. Одоо энэ газар олголт нэг хэсэг нь алга дарам газар 0.7-г ч авч чадахгүй байж байхад нэг хэсэг нь хэдэн гагаар нь хэд хэдэн бүх газрууд дээр орон нутаг болгонд, Улаанбаатар хотод хэдэн 10-аар нь авчихсан байж байгаа байхгүй юу. Тэгээд одоогийн хууль чинь өөрөө болохоор мөнгөтэй хүн нь л авах дуудлага худалдаагаар авдаг болохоор мөнгөтэй хүн нь л авах бололцоо боломж үүсчихсэн. Тэгэхээр та нар энэ цахимжуулалтаа хурдан хийгээд, ер нь Монгол Улсад хамгийн их газар авсан хүн хэн байна. Иргэн, аж ахуйн нэгж. Гэтэл цаана чинь иргэд 0.7-оо авах гэж орон нутгийн газрын алба дээр яаж их очер

дугаарлаж байна. Энийг та нар маань яаралтай цахимжуулж цахимжуулахгүй бол энэ бол харагдахгүй байгаа. Тэр сумд очиж нэг газар аваад л, энэ сумд очиж нэг газар аваад л, энэ дүүрэг дээр ирж нэг газар аваад л гэнэ. Энийг өнөөдөр хэн ч яаж ч авч байгааг мэдэх бололцоо боломж байхгүй байна. Тийм учраас танай яамнаас газар.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Энхманлай дарга асуултад хариулъя.

А.Энхманлай: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Газрын харилцааг цэгцлэх газрын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бид бүхэн бас нэлээд ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа. Энэ хүрээнд саяын асуусан асуулттай холбоотой ер нь Монгол Улсын хэмжээнд 4 шатын газар болон хот байгуулалтын төлөвлөгөөнүүд хэрэгжээд явж байгаа. Гэтэл яг таны саяын асуултад яригдаж байгаа зарим аймаг сумууд газар зохион байгуулалтын төлөвлөгөө байхгүй, хот байгуулалтын төлөвлөгөө байхгүйгээр газар олголтынхоо асуудлыг ишидээд яваад байгаа юм. Энэ бол маш том зөрчил. Бид бүхэн судалгаа хийж үзсэн. Одоо бол Говь-Алтай аймаг дээр жишээлбэл ерөнхий төлөвлөгөө байхгүй явж байгаа. 117 сум дээр сумаа хөгжүүлэх төлөвлөгөө байхгүй явж байгаа юм. Тэгэхээр юуг үндэслэж ингээд газар олгоод байгаа нь бол тэр сумын сумын Засаг дарга нар бол.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй нэг санал байгаа юм байна. Унишж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 18.1.10 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүд

анхааралтай байгаарай. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Саяын санал хураалтыг хүчингүй тооцож өгнө үү. Миний өгсөн санал эсрэг гарчихлаа.

Г.Тэмүүлэн: Төхөөрөмж сайн ажилласангүй. Раднаасэд гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Дахиад гишүүд анхааралтай байгаарай. Раднаасэд гишүүний төхөөрөмж ажиллахгүй байгаад байна. Та картаа солиод хажуу тал руугаа хийж үзэх үү. Дахиад нэг хийгээд үзье. Төхөөрөмж нь ажиллахгүй байна. Ирцэд орлоо. Одоо дахиад Раднаасэд гишүүний саналаар санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. Батсуурь гишүүн санал гаргах уу. Батсуурь гишүүн санал гаргая.

Ж.Батсуурь: Төхөөрөмж гацаад сая миний санал орсонгүй.

Г.Тэмүүлэн: Батсуурь гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ. Санал хураалт дэмжигдсэн тул ажлын хэсэг түрүүний санал хураалтыг дахин явуулъя. Ингээд ажлын хэсгийн гаргасан санал хураалтыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 4 саналтай байгаа юм байна. 4 саналыг тус бүрээр нь унишж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.3 дахь хэсгийн “сумын газар зохион

байгуулалтын” гэснийг “энэ хуулийн 25.1.4-т заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.2.4 дэх заалтын “эрхлэх,” гэсний дараа “тухайн жилд” гэж нэмэх. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. 54,5 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.10 дахь заалтын “байгууллага, мэргэжлийн байгууллагад” гэснийг “байгууллагад мэргэжлийн байгууллагын” гэж өөрчлөн, “, дүгнэлт өгөх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Раднаа гишүүнийх л болохгүй байна даа төхөөрөмж. Та санал гаргачих уу. Суудлаа сольж байгаад, төхөөрөмжөө солиод нэг үзье дээ. Та санал гаргачих. Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Энэ санал хураалтын төхөөрөмж гацаад байгаа тул дахиж санал хураалт явуулж өгөхийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Раднаасэд гишүүний саналаар санал хураалтыг дахин явуулъя. Раднаасэд гишүүний төхөөрөмж болохгүй байгаад байна. Дахиад санал хураалтыг явуулъя. Төхөөрөмж нь ажиллахгүй байгаа учраас санал хураалт. Техникийн хүмүүс байвал ирж туслаарай. 54,5 хувиар дэмжигдлээ.

Энэ дэмжигдсэн тул ажлын хэсгээс гаргасан 2 дахь санал буюу Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.10 дахь заалтын “байгууллага, мэргэжлийн байгууллагад” гэснийг “байгууллагад мэргэжлийн байгууллагын” гэж өөрчлөн, “, дүгнэлт өгөх” гэснийг хасах. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 23.2.15 дахь заалтын “Засгийн газарт” гэснийг “холбогдох хуульд заасан эрх бүхий этгээдэд” гэж өөрчлөх. Санал гаргасан

ажлын хэсэ. Санал хураалт. 54,5 хувиар дэмжигдлээ.

5. Төслийн 2 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 23.2.16 дахь заалт нэмэх:

“23.2.16.улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Төхөөрөмж яагаад гацав. 54,5 хувиар дэмжигдлээ.

2 дугаар зүйл дээр нэмж Раднаасэд гишүүн санал гаргасан байна.

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга объектыг төрийн өмчид хураан авах ажлыг зохион байгуулах.” гэсэн саналыг гаргаж байгаа юм байна. Раднаасэд гишүүн саналаа тайлбарлая. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Ингээд шүүхийн шийдвэрээр хууль бус болох нь тогтоогдсон газрууд маш их байгаа. Тэгээд нурааж болдоггүй. Энэ авлига хороолол гээд. Маш их хэмжээний хөрөнгийн асуудал цаана нь явна. Тийм үү. 2 дугаарт бусад өөр юу байна. Төрийн өмчит ерөөсөө авах юм. Энэ хууль бус болох нь тогтоогдох юм бол гэх юм бол тэр лүү чинь хүн очиж байшин барихгүй шүү дээ. Тэртээ тэргүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг дээр байгаа. Энэ Хавдрын эмнэлэг, Халдвартын эмнэлгийг өргөтгөөдөхье гэхээр хаашаан дотор нь байшин барьчихсан. Тэгээд өөр тийшиээ нүүхээс өөр аргагүй болдог. Өөр тийшиээ нүүхээр дэд бүтцийн асуудал дахиад л бөөн зардал. Тийм учраас энэ өөрөө урьдчилан сэргийлэх газраа хамгаалж байгаа том бодлого. Нэг талдаа хүний юмыг хурааж авах гээд байгаад байгаа юм биш. Тэртээ тэргүй хууль бусаар шүүхийн шийдвэрээр ямар нэгэн байдлаар тогтоогдох юм бол төр авчих юм байна гэдэг тэр ойлголтоо хүн мэдэж байгаа бол хэн ч тэр газрыг авч

байшин барьчихъя гэж оролдохгүй шүү дээ. Тэгээд энийг дэмжээд явчих юм бол бараг энэ бүх юмны зангилаа тайлагдах болов уу гэж байгаа. Одоо энэ авлига хорооллыг бид нар яах бол. Мэдэхгүй ээ, энийг бол маш их хэмжээний хүний хөрөнгө бас цаана нь үрэгдэж байгаа шүү дээ. Өгсөн нь яах вэ, аваад барьчихсан нь бас яах вэ гээд. Монгол Улс түүхэндээ нэг л их том барилгыг нураасан. Тэр бол Барилгачдын талбай дээр баригдаж байсан 3 давхар барилгыг нураасан нэг л түүхтэй. Өөр хэзээ ч ингэж хүний өмчийг алдаж нурааж байсан тийм юм бол ерөөсөө байхгүй. Шүүхийн шийдвэрээр. Шүүхийн шийдвэр нь ч гардаггүй ингээд гацаад алга болчихдог. Тийм учраас энүүгээр өөрөө энэ газар дээр барилга байшин барих гэж байгаа хүмүүсийг 1 дүгээрт том хамгаалалт урьдчилан сэргийлж өгч байна. Нөгөө талдаа төр өөрийнхөө газрыг хамгаалж үлдэхгүй бол энд чинь ерөөсөө нийтийн эзэмшлийн газар талбай руу ороод эхэлж байна шүү дээ. Гишүүд энийг дэмжиж өгөхийг хүсэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 36,4 хувиар, 63,6 хувиар дэмжигдсүгэй.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төсөл нь 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. 5 дугаар зүйл дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 1 санал байгаа юм байна. Нэг саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

16.Кадастрын зураглал бага газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг 2 дугаар зүйл дээр 3 зарчмын зөрүүтэй саналтай юм байна. Саналуудыг тус бүрээр уншиж танилцуулъя.

1 дүгээр зүйл дээр юм байна. Тийм байна ажлын хэсгийнх юм байна. Энийг залруулъя. Томьёолол дээр буруу бичиж оруулсан байна шүү.

Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2.8, 10.2.9 дэх заалт нэмсүгэй:

“10.2.8.бүх ангиллын кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлуулан мөрдүүлэх;

10.2.9.газрын кадастр хийх нутаг дэвсгэрийн ээлж дарааллыг тогтоох, газрын кадастрын судалгааг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавих;" Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 54,5 хувиар дэмжигдлээ.

Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8 дахь заалтын дугаарыг “10.2.10” гэж өөрчилсүгэй.”

3 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийг хүчингүй болгосугай. ” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. Раднаасэд гишүүний төхөөрөмж ажилладаггүй ээ. Энийг техникийг дуудъя байна уу? Төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах хүртэл Байнгын хорооны хуралдааныг түр завсарлууллаа. 14 цаг хүртэл. Баярлалаа.

ЗАВСАРЛАГА.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүн санал гаргах юм байна. Өмнөх санал хураалт дууссан. Төхөөрөмжийн бүрэн бус байдлаас болоод саналууд унасан байгаа. Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Өмнөх санал хураалтыг хүчингүй болгож, дахиж санал хураалгаж өгнө үү гэж горимын санал гаргаж байна.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүний саналаар санал хураалтыг явуулъя. Өмнөх санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8 дахь заалтын дугаарыг “10.2.10” гэж өөрчилсүгэй.”

3 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийг хүчингүй болгосугай. ” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

3.Найруулгын санал. Төслийн 2 дугаар зүйлийн дугаарыг 4 дүгээр зүйл болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 60 хувиар дэмжигдлээ. Ингээд ажлын хэсгийн 3 санал хурааж дууслаа.

17.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Та нар маань нөгөө агентлагаа ерөнхий сайдын дэргэд авч ирээд энэ газрын төлбөрөөс орох орлогыг хаана төвлөрүүлэх гэж байна. Одоо бид нар нэгжгийн хууль нэгжгийн хуулиар орон нутагтаа өгсөн. Тэгвэл одоо Ерөнхий сайдын дэргэд агентлагт ирснээр төлбөрийг хаана хурааж, хаана зарцуулах гэж байна. Орон нутгаас нь бас төвлөрдөг орлогыг нь булаагаад дээшээ босоо авчихаж байгаа юм биш биз дээ. Энийг тайлбарлаж өгөөч.

Г.Тэмүүлэн: ажлын хэсэг асуултад хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон. 6 дугаар микрофон байна.

А.Энхманлай: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Дагалдах хуулиар ерөөсөө газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Барилга, хот

байгуулалтын яамнаас Ерөнхий сайдын мэдэл рүү шилжиж байгаа болохоос бусад чиг үүргүүд бол шилжээгүй. Газрын төлбөрийн хувьд бол орон нутагтаа газрын төлбөрийн орлого нь төвлөрдгөөрөө төвлөрнө. Харин газрын харилцааны байгууллага бол зөвхөн ногдуулах ажлыг хийнэ. Татварын байгууллага хураах ажлаа хариуцахаар ингэж зохион байгуулсан. Орж байгаа орлого бол орон нутгийн төсөвт.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хариулт хангалттай юу Сандаг-Очир гишүүн ээ. Ойлголоо. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс найруулгын санал байгаа юм байна.

Найруулгын саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэснийг “болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу. Алга байна.

18.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 4 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй

санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

19.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 2 саналтай байна. 2 саналыг уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “бүхий QR код (лавлагаа авах холбоос)” гэснийг, тус зүйлийн “, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “энгийн” гэсний дараа “болон тусгай” гэж, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа” гэсний дараа “ажлын” гэж тус тус” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсэг 1 санал байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн “бичиг” гэсний өмнө “олгоно.” гэсний өмнөх” гэж, мөн зүйлийн “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 5.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хугацаа 10 хоног” гэснийг “хугацаа ажлын 10 өдөр” гэж тус тус” гэж

нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

20. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

21. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 3 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу. Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух болон зарчим зүйтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй 2 саналтай юм байна. 2 саналыг уншиж танилцуулъя.

Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэснийг болон 2 дугаар зүйлийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

3 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байгаа. Төслийн 3 дугаар зүйлийг 2 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

Хуулиуд дуусаад, одоо Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцье.

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Тогтоолын төсөлд ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураана.

Төслийн гарчгийг “Тогтоолд нэмэлт оруулах тухай” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26,” гэсний дараа “27,” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

3. Тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2. Энэ тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.” Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

4.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

2. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

Тогтоолын төсөлд ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хурааа.

Төслийн 1 дэх заалтын “төсвийн тухай хууль” гэснийг “төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

3. “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

4. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Ажлын хэсгээс нэг санал байгаа юм байна.

Төслийн тэмдэглэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газрын” гэсний өмнө “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг,” гэж

нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

5. “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Тогтоолын төсөлд ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналууд байна. Нийт 6 санал байна. Саналыг тус бүрээр нь санал хураалга.

Төслийн 1 дэх заалтын “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, төвлөрлийг сааруулах зорилгоор 2024 оныг “Хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих” жил болгон зарласугай.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчилж, тус заалтын 11 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11/ Газрын багц хуулийн төсөл, түүнд нийцүүлэн Ашигт малтмалын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулан 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

3 Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 12 дахь дэд заалт нэмэх:

“12/төсвийн ил тод, хариуцлагатай байх зарчимд нийцүүлж төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөр, арга хэмжээний үр дүн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж

түүнтэй уялдсан төсвийн зардлыг тооцож боловсруулж байх;" Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг байгаа. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын "нийтлэг" гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 3 дахь заалтыг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

6. Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай:

1/орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нийслэл, орон нутагт үе шаттайгаар нэмэгдүүлэх;

2/ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө орон нутгийн иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах;

3/агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м²-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах." Санал гаргасан ажлын хэсэг, Их Хурлын гишүүн Бямбацогт гэсэн ийм санал байна. Үүгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

7 Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

"3.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төр, хувийн хэвилийн түншлэлийн тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг сунгах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай." Санал гаргасан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

8.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

"5.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй." Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60 хувиар дэмжигдлээ.

"Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол бас ирсэн юм байна. Энийг ажлын хэсэг бэлдсэн юм уу. Би уншаад танилцуулаадахья.

Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай дэд заалт шинээр нэмэх:

3/Ипотекийн зээлийн 60 хувийг хөдөө орон нутагт орон сууцжуулах хөтөлбөрт хуваарилах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг. Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга санал хэлье.

Д.Тогтохсүрэн: Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байгаа юм. Тэгэхээр түрүүн ажлын хэсгийн санал дээр хураагдаад энэ дэмжигдсэн учраас энэ саналыг хураагдсан гэж тооцоод явчихмаар байна. Дараагийнх нь

заалт болохоор Ганибал гишүүний санал байгаа юм. Энэ 60 хувийг дэмжихгүй гэсэн санал байгаа юм. Тийм биз дээ. Монгол банканд чиглэл өгч бол болохгүй гэсэн агуулгатай юм байсан. Тэгээд түрүүн бид нар Монгол банканд чиглэл өгсөн тогтоол баталчихсан. Ипотекийн зээлтэй холбоотой асуудлаар. Тийм учраас энэ саналыг бол би хураах шаардлагагүй ээ гэж ингэж бодож байгаа. Нөгөө санал нь дэмжигдчихсэн учраас. Дэгийн хуулиар.

Г.Тэмүүлэн: Өмнөх санал дэмжигдсэн учраас энэ 2 саналыг хураах шаардлагагүй гэдэг асуудлаар санал хураалтыг явуулчихъя. Санал хураалт. Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

6. “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна.

7. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Алга байна. Тогтоолын төсөлд ажлын хэсгээс гарсан санал байгаа юм байна. Би энийг уншиж танилцуулъя.

1. Төслийг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй нэгтгэж нэг төсөл болгон, төслийн 1 дэх заалтыг “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтын 13 дахь дэд заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13/хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан болон тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, төмөр зам, нисэх буудал, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчлэх, боомтын хүчин чадлыг сайжруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц бий болгох болон төрийн үйлчилгээний салбарын төсөл хөтөлбөрийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Найруулгын нэг санал байгаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 70 хувиар дэмжигдлээ.

Ингээд хууль, тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Ингээд анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга нэгдсэн хуралдаан танилцуулна.

Ингээд хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууслаа. Ажлын хэсгийн гишүүд болоод Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

15.07 цаг.

*Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ